



**“ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН СУРАГЧДЫН ХИЧЭЭЛ,
СУРЛАГЫН ХОЦРОГДЛЫГ НӨХӨХ, АРИЛГАХ
ЦОГЦ ТӨЛӨВЛӨГӨӨ
(2021-2023)”-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙН
ЯВЦАД ХИЙСЭН ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭ**

“Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хичээл, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах цогц төлөвлөгөө /2021-2023/”-ний хэрэгжилтийн явцад хийсэн хөндлөнгийн үнэлгээ

ЗӨВЛӨХ Ш.Оюунцэцэг

СУДЛААЧ Б.Батхүү

Хэвлэлийн эх бэлтгэсэн:

Цаасны хэмжээ: В5

Хэвлэлийн хуудас:

Хавтасны зургийг Б.Инжинаш, Д.Давааням, Б.Тамир

“Боловсролын төлөө чанга дуугарцгаая” төслийн санхүүжилтээр хийж гүйцэтгэв.

ТАЛАРХАЛ

“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн захиалгаар 2021 онд Боловсрол Шинжлэх Ухааны сайдын баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хичээл, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах цогц төлөвлөгөө /2021-2023/”-ний хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийж гүйцэтгэлээ. Үнэлгээ нь 2023 оны 11 дүгээр сар хүртэлх хугацаанд тус төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг үнэлж, цаашдын хэрэгжилтэд зориулж сайн туршлагыг баримтжуулах, зөвлөмж боловсруулах зорилготой байв.

Үнэлгээний хүрээнд асуумж судалгаа болон ганцаарчилсан ярилцлагад хамрагдаж, өөрсдийн туршлага, санал бодлыг хуваалцсан боловсролын салбарын харьяа байгууллагуудын төлөөлөл, ерөнхий боловсролын сургуулийн багш нарт гүн талархал илэрхийлье. Мөн үнэлгээний мэдээлэл цуглуулах ажилд дэмжлэг үзүүлсэн “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн гишүүн байгууллагууд, Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (БХАН)-ийн хамт олонд талархал илэрхийлж байна. Түүнчлэн энэ ажлыг зохион байгуулж, бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлсэн “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн ерөнхий зохицуулагч Д.Тунгалаг, дэд зохицуулагч Я.Мөнхчимэг, хөтөлбөрийн ажилтан Б.Батчимэг, БХАН-ийн гүйцэтгэх захирал Б.Батжаргал нарт баярлалаа.

Үнэлгээнээс гарсан үр дүн, мэдээллүүд нь цогц төлөвлөгөөний цаашдын хэрэгжилт болон сурагчдын сурлагын хоцрогдлыг арилгах дараагийн ажлуудад хувь нэмэр оруулна гэж найдаж байна.

Судлаачид:

Ш.Оюунцэцэг

Б.Батхүү

АГУУЛГА

ТАЛАРХАЛ	1
АГУУЛГА	2
ХҮСНЭГТ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	3
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	4
НЭГ. ЦОГЦ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЛААРХ ТОЙМ	5
ХОЁР. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ	9
2.1. Үнэлгээний зорилго	9
2.2. Үнэлгээний хүрээ болон үндсэн асуултууд	9
2.3. Үнэлгээний мэдээлэл цуглуулах аргууд	10
2.4. Үнэлгээний түүврийн хэмжээ, бүрэлдэхүүн	10
2.4.1. Тоон судалгааны түүвэр	10
2.4.2. Чанарын судалгааны түүвэр	11
ГУРАВ. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН	13
3.1. Цогц төлөвлөгөөний төлөвлөлтийн ач холбогдолтой, тохиромжтой байдал	13
3.1.1. Цогц төлөвлөгөө цаг үеэ олсон, ач холбогдолтой эсэх	13
3.1.2. Цогц төлөвлөгөөний төлөвлөлтийн уялдаатай байдал	17
3.2. Үр дүнтэй, үр ашигтай байдал	18
3.2.1 Цогц төлөвлөгөөний талаарх талуудын ойлголт	18
3.2.2. “Эргэн холбогдох” буюу нэгдүгээр зорилтын хэрэгжилт	19
3.2.3. “Хичээл, сурлагын хоцрогдлыг нөхөх” буюу хоёрдугаар зорилтын хэрэгжилт	25
3.2.4. Цогц төлөвлөгөөний хэрэгжилтэд нөлөөлж буй хүчин зүйлс, сургамж, ажиглалт	34
3.3. Цогц төлөвлөгөөний тогтвортой байдал	38
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ	41
ТАВ. БОДЛОГО ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨМЖ	43
ХАВСРАЛТ	44

ХҮСНЭГТ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Үнэлгээний хүрээ, асуултууд	13
Хүснэгт 2.	Үнэлгээний мэдээлэл цуглуулах арга, зорилго, хамрах хүрээ	15
Хүснэгт 3.	Чанарын судалгааны түүврийн бүрэлдэхүүн	17
Хүснэгт 4.	Цогц төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн	22
Хүснэгт Х-5	Тоон судалгаанд хамрагдсан багш нарын тоо, байршлаар	59
График 1.	Судалгаанд оролцсон багш нарын байршил (n=1,244)	16
График 2.	Багш нарын төрөл, заадаг хичээлээр (n=1,244)	16
График 3.	Цогц төлөвлөгөөний талаарх мэдлэг ойлголт	27
График 4.	Зорилтод туссан судалгаа, оношилгоог хийсэн эсэх, (n=1,244)	31
График 5.	Сурагчдын нийгэм-сэтгэлзүйн байдлыг дэмжихэд зориулж зохион байгуулсан үйл ажиллагаанууд (олон сонголттой, n=779)	33
График 6.	Сурагчдын нийгэм-сэтгэлзүйн байдлыг дэмжихэд зориулж зохион байгуулсан үйл ажиллагаануудын үр дүн	33
График 7	Сургууль болон багш нар ерөнхий, нэмэлт, тусгай дэмжлэг үзүүлсэн эсэх (n=1,244)	40
График 8	“Сурагчийн бие даан суралцах ажлын дэвтэр”-ийн үр дүн (n=1,244)	42
График 9	Багш нарын сургалтад хамрагдсан байдал (n=1,244)	44
График 10	Багш нарыг чадавхжуулах сургалтуудын үр дүн	44
График 11	Сурагчдын сурлагын хоцрогдол нөхөгдсөн эсэх, багш нарын хувиар (n=1,244)	46

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

БШУЯ	Боловсрол, Шинжлэх Ухааны Яам
БЕГ	Боловсролын Ерөнхий Газар
БМДИ	Багшийн мэргэжил дээшлүүлэх институт
БСҮХ	Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн
БҮТ	Боловсролын үнэлгээний төв
БХАН	Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОУБ	Олон улсын байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
ШХА	Швейцарын Хөгжлийн Агентлаг

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

НЭГ. ЦОГЦ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЛААРХ ТОЙМ

Ковид-19 цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд болон холбогдох эрх зүйн баримт бичгүүд, мөн 2020 оны 4 дүгээр сард батлагдсан “Коронавируст халдвар /Ковид-19/-ийн цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-ийн 7.1.9 дэх заалтыг үндэслэн Засгийн газраас бүх шатны сургалтын байгууллагын үйл ажиллагааг тодорхой хугацаагаар зогсоож зайн сургалтад шилжүүлэх арга хэмжээ авчээ. Монгол Улсын Онцгой комиссын хуралдаанаар бүх шатны боловсролын байгууллага, сургалтын төвийн хичээл, сургалтын үйл ажиллагааг 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс түр хугацаагаар хаасан байна. Тухайн үед цогц төлөвлөөг боловсруулсан ажлын хэсэг танхимын сургалт хаагдсанаас хойш аль ч ангийн сурагчдын хувьд ойролцоогоор нэг жилийн хугацааны хоцрогдол үүссэн бол нэг сурагчийн хувьд дор хаяж 1-1.5 жилд судлах агуулгыг бүрэн гүйцэд судалж чадалгүй сурлагын хоцрогдолд орсон гэсэн тооцооллыг хийжээ.

Ийм учраас Ковид-19 цар тахлаас үүдэлтэй сурагчдын хичээл, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах зорилгоор “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хичээл, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах цогц төлөвлөгөө /2021-2023/-г (цаашид Цогц төлөвлөгөө гэх) Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 05-р сарын 21-ний өдрийн А/190 дүгээр тушаалаар баталсан. Цогц төлөвлөгөө нь дараах 10 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

1. Нийтлэг үндэслэл
2. Ковидын үеийн хичээл сурлагын хоцрогдлын нөхцөл байдал
3. Хичээл сурлагын хоцрогдол нөхөж байгаа олон улсын туршлага
4. Цогц төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд баримтлах зарчим
5. Хичээл сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах, суралцахуйг дэмжих тогтолцоо
6. Цогц төлөвлөгөөний зорилго, стратеги

7. Цогц төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт
8. Цогц төлөвлөгөөг хэрэгжүүлэх төсөв
9. Цогц төлөвлөгөөний хяналт
10. Ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-ийн сурагчдын хичээл, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах цогц төлөвлөгөө

Цогц төлөвлөгөөний зорилго нь цар тахлын үеийн хөл хорионы улмаас бий болсон сурагчдын хичээл, сурлагын хоцрогдол нөхөх, арилгах, тэдний суралцахуйг дэмжих үйл ажиллагааг удирдан зохион байгуулахад оршино. Цогц төлөвлөгөөг 2021-2023 онд хэрэгжүүлж, сурагчдын хичээл, сурлагын хоцрогдлыг гурван жилд багтаан нөхөж, арилгахаар төлөвлөжээ.

Цогц төлөвлөгөө боловсруулахдаа 3R буюу эргэн холбох, нөхөж арилгах, тогтворжуулах гэсэн гурван шатлал бүхий загварыг үндэслэсэн бөгөөд дараах гурван зорилт дэвшүүлжээ. Үүнд:

- **Эргэн холбогдох:** Сурагч, багш, эцэг эх, сургуулийн хэрэгцээг тодорхойлж, эргэн холбогдох сэтгэл зүйн орчин бүрдүүлж ажиллах;
- **Хичээл, сурлагын хоцрогдлыг нөхөх:** Хосолсон сургалтын дэд бүтэц, цахим сан бүрдүүлж, тэгш хамруулах зорилго бүхий суралцахуйг дэмжих тогтолцоог хэрэгжүүлэх, өөрийн удирдлагатай сургалтын арга зүйг нэвтрүүлэх;
- **Хичээл, сурлагын хоцрогдлыг арилгах/тогтворжуулах:** Сургууль, орон нутаг залруулга бүхий дэмжих тогтолцоог бие даан хэрэгжүүлдэг болох¹.

“**Эргэх холбогдох**” буюу нэгдүгээр зорилтын хүрээнд сургууль, багш нар бүхий л боломжийг ашиглан сурагч, эцэг эхтэй холбоо харилцаагаа сэргээх, сурагчдыг сургуульдаа эргэн ирэхэд нь эерэг таатай уур амьсгал бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг гурван стратегийн хүрээнд төлөвлөжээ.

“**Хоцрогдлыг нөхөх**” буюу хоёрдугаар зорилтын хүрээнд хосолсон сургалтын орчин, цахим сургалтын дэд бүтцийг бэхжүүлэх, үнэлгээний цахим платформ хөгжүүлж нэвтрүүлэх, сурлагын хоцрогдол нөхөх дэмжигч болон дадлагын багш, зуны сургалтын явуулын багш, явуулын сэтгэл зүйч, дотуур байрын багшийг бэлтгэх, сургалт зохион байгуулах, сурагчдын бие даан суралцах ажлын дэвтэр, ажлын хуудас, дасгал ажлын дэвтэр боловсруулж хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг 5 стратегийн хүрээнд төлөвлөжээ. Сурлагын хоцрогдол нөхөх, суралцахуйг дэмжих тогтолцоо бүрдүүлэхийг зорьж, ерөнхий дэмжлэг үзүүлэх үндсэн багш нараас гадна сурагчдад нэмэлт дэмжлэг үзүүлэх дэмжигч багш, дагалдан багш; тусгай дэмжлэг үзүүлэх сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, дотуур байрын багш, сургуулийн эмч эцэг, эх хамтран ажиллах үйл ажиллагаануудыг төлөвлөсөн.

¹ БШУЯ (2021). Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах цогц төлөвлөгөө

“Цогц төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт” бүлэгт сургууль, орон нутаг, үндэсний гурван түвшинд тус бүрээр төлөвлөгөөний хэрэгжилтийг дэмжин ажиллах чиглэлийг тодорхойлж, удирдлага, зохион байгуулалтыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжүүлэгч талууд болон олон нийтийн оролцоог тодорхойлсон.

Ерөнхий боловсролын сургуулийн хичээл сурлагын хоцрогдлыг 2020-2021, 2021-2022, 2022-2023 оны хичээлийн жилд нөхөх график гаргасан бөгөөд 2021 онд агуулгын хоцрогдол (бага ангид унших, бичих, математик чадварыг; дунд ангид сурах арга барил болон монгол хэл, математик, байгалийн ухааны агуулгын хоцрогдол; ахлах ангид монгол хэл, математик, сонгон судлах хичээлийн агуулга), 2022 онд бүх хичээлийн агуулгын болон сурах арга барилын хоцрогдлыг арилгана гэж үзжээ. Ийнхүү хоцрогдлыг нөхөж арилгах зорилгоор сургуулиуд ментор, дэмжигч, дадлагажигч багш нарыг танхимын ба танхимын бус цагаар ажиллуулах; бага, дунд ахлах ангийн сурагчдын мэдлэг, чадварыг оношлох үнэлгээний арга зүй, аргачлал, хэрэгслийг хэвлэж түгээх, 2020-2021, 2021-2022, 2022-2023 оны хичээлийн жилд сурагчдын бие даан ажиллах дэвтрийг бага, дунд, ахлах ангиар ялгаатай боловсруулж, сургуулиудад хүргэхээр төлөвлөжээ.

2021 онд танхимын хичээл үргэлжлэх боломжгүй болсон тохиолдолд алслагдсан баг, тосгоны сурагчдыг хоёр долоо хоногийн зуны сургалтад хамруулж, явуулын багш нараар хичээл заалгах, мөн орон нутгийн арга зүйч, мэргэжлийн бүлгүүд, үндсэн багш, нийгмийн ажилтан, эмч, сэтгэл зүйчдийг хоцрогдол нөхөх менежмент, арга зүй, үнэлгээний нэгдсэн сургалтад хамруулах, мөн хоцрогдол нөхөх төлөвлөгөөг орон нутаг, сургууль, багш, сурагчид боловсруулж, хоцрогдлыг нөхөж ажиллахаар төлөвлөсөн.

“Хоцрогдлыг арилгах, тогтворжуулах” буюу гуравдугаар зорилтын хүрээнд сурлагын хоцрогдлыг богино хугацаанд нөхөх, суралцахуйг дэмжсэн сургууль, багш нар туршлагаа хуваалцах, түгээн дэлгэрүүлэх, сурлагын хоцрогдлыг тухай бүрд нь залруулдаг суралцахуйг дэмжих тогтолцоо бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаануудыг төлөвлөжээ.

Сурагчид хугацааны болон агуулгын хоцрогдлыг 3 жилийн турш нөхөх боломжтой гэж үзсэн бөгөөд тухайн ангид судлах хичээлийн агуулгад шингээн судлах замаар эзэмшүүлэх юм байна. Үүнийг теле хичээлд хамрагдаагүй II ангийн сурагчаар жишээлэн хоцрогдол нөхөх, арилгах үе шатыг үзүүлж, бусад ангийн хувьд ч ийм зарчмаар агуулгын хоцрогдлыг нөхөж, арилгах боломжтой гэж үзжээ.

1. 2021 оны намар теле хичээлд огт хамрагдаагүй сурагчдыг 6 дугаар сард зуны сургалтад хамруулж, теле хичээлийн агуулгын зөрүүг нөхнө.

2. 2021-2022 оны хичээлийн жил буюу III ангид үндсэн агуулгын хажуугаар I ангийн агуулгын 20%, II ангийн агуулгын 60%-ийг шингээн судална.
3. 2022-2023 оны хичээлийн жилд IV ангид II ангийн агуулгаас үлдсэн 20%, III ангийн агуулгаас үлдсэн 20%-ийг тус тус шингээн судлах замаар хоцорсон агуулгыг бүрэн нөхөж дуусгахаар төлөвлөжээ.

Цогц төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гурван жилийн хугацаанд нийт 327 тэрбум төгрөгийн төсөв шаардагдана гэж тооцоолсон бөгөөд улсын төсөв болон олон улсын хөгжлийн түншлэгч байгууллагууд, тухайлбал НҮБ-ын Хүүхдийн сан, Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, Швейцарын хөгжлийн агентлаг (ШХА), Японы олон улсын хамтын ажиллагааны Жайка байгууллага, Дэлхийн зөн олон улсын байгууллага зэргийн санхүүгийн дэмжлэгтэй хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Цогц төлөвлөгөөний онцлог:

1. Цогц төлөвлөгөөг дэлхийн улс орнуудад хичээл, сурлагын хоцрогдлыг нөхөх арга хэмжээнд хэрэглэж буй сайн туршлагыг судалсны үндсэн дээр тухайн цаг үед цөөнгүй улс орны хэрэглэж эхэлсэн 3R (Reconnection, Recovery, Resilience) буюу эргэн холбох, нөхөх, тогтворжуулах гэсэн 3 шатлал бүхий загварт суурилан 10 стратеги баримтлан ажиллахаар боловсруулсан. Түүнчлэн Финлянд улсын сурлагын хоцрогдолтой хүүхдийг дэмжих тогтолцоо (The support system)-г сонгож, өөрийн орны онцлогт тохируулан 10 стратегиар хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Энэхүү тогтолцоо нь орчин үеийн сургалтын онолын нэг чиглэл болох өөрийн удирдлагатай суралцахуйн (Self-regultaed learning) онолд тулгуурладаг бөгөөд өөр хоорондоо уялдаа холбоо бүхий 3 шатлалтай хэрэгжинэ. Үүнд: а) Тусгай дэмжлэг (Special support), б) Нэмэлт дэмжлэг (Intensified support), в) Ерөнхий дэмжлэг (General support).
2. Цогц төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, сурагчдын хичээл, сурлагын хоцрогдлыг арилгах, суралцахуйг дэмжихэд олон талын үүрэг оролцоо, тэдгээрийн үйл ажиллагааны уялдаа холбоотой байхыг чухалчилж, Монгол Улсын Засгийн газар, БШУЯ болон түүний харьяа мэргэжлийн байгууллагууд, олон улсын хөгжлийн түншлэгч байгууллага, орон нутгийн хөгжлийн байгууллага, сургуулиуд, сургалтын төвүүдийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, мөн багш, эцэг эх, иргэний нийгмийн байгууллагын оролцоог тодорхойлсон.
3. Цогц төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлгээ ба хяналт-шинжилгээ хийх ажлын зохион байгуулалтыг 1) гарааны үнэлгээ буюу оношлох үнэлгээ, 2) явцын хяналт шинжилгээ, 3) жилийн гүйцэтгэлийн үнэлгээ

(2021, 2022 он), 4) үр дүнгийн үнэлгээ (2023 он), 5) хөндлөнгийн үнэлгээ (2023-2024) гэж нарийвчлан тодорхойлсон.

4. Цогц төлөвлөгөөний 10 стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээ бүрээр явц, үр дүнг гурван жил тутамд үнэлж байхаар 88 шалгуур үзүүлэлтийг цогц байдлаар тусгайлан боловсруулсан (1-р зорилт 18; 2-р зорилт 53; 3-р зорилт 10; Хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээ-7 шалгуур) зэрэг болно.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ХОЁР. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

2.1. ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Энэхүү хөндлөнгийн үнэлгээ нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 5 сарын А/190 тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хичээл, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах цогц төлөвлөгөө”-ний 2020-2021, 2021-2022, 2022-2023 он буюу энэ гурван хичээлийн жилийн хэрэгжилтэд үнэлгээ өгч, цаашид хэрэгжүүлэх сайн туршлагыг баримтжуулах, зөвлөмж боловсруулах зорилготой.

2.2. ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭ БОЛОН ҮНДСЭН АСУУЛТУУД

Үнэлгээний баг нь энэ үнэлгээг хийхдээ цогц төлөвлөгөөний эцсийн үнэлгээ гэж үзээгүй тул үр нөлөөг нь үнэлэхийг чухалчлаагүй. Харин 2023 оны 10 сар хүртэлх хугацаанд уг төлөвлөгөөний хэрэгжсэн байдалд гол анхаарлаа хандуулж, (i) ач холбогдолтой, тохиромжтой байдал, (ii) үр дүнтэй, үр ашигтай байдал, (iii) тогтвортой байдал гэсэн үндсэн гурван шалгуурын хүрээнд зохион байгуулсан бөгөөд үнэлгээ бүрээр үндсэн болон дэд асуулт боловсруулан (Хүснэгт 1), тэдгээрийн хүрээнд мэдээлэл цуглуулах, боловсруулалт хийсэн болно.

Хүснэгт 1. Үнэлгээний хүрээ, асуултууд

Үнэлгээний шалгуур	Үндсэн асуулт	Дэд асуултууд
Ач холбогдолтой, тохиромжтой байдал	EQ1. Цогц төлөвлөгөөний төлөвлөлт хэр зэрэг оновчтой, ач холбогдолтой, уялдаатай байна вэ?	1.1. Цогц төлөвлөгөө хэр зэрэг ач холбогдолтой вэ?
		1.2. Цогц төлөвлөгөө боловсруулахад талуудын оролцоог хэр зэрэг хангасан бэ?
		1.3. Цогц төлөвлөгөөний нь дэвшүүлсэн зорилго, зорилтдоо хүрэхэд хэр зэрэг оновчтой төлөвлөгдсөн бэ?
		1.4. Цогц төлөвлөгөө нь бусад холбогдох бодлого, төлөвлөгөө, стратеги, төсөл, хөтөлбөрүүдтэй хэр зэрэг уялдаа холбоотой байна вэ?

Үр дүнтэй, үр ашигтай байдал	EQ2. Цогц төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, стратегиудын хэрэгжилт хэр ахицтай байна вэ?	2.1. Цогц төлөвлөгөөний (1) Эргэн холбогдох; (2) Хичээл, сурлагын хоцрогдлыг нөхөх зорилтын хүрээнд төлөвлөгдсөн арга хэмжээнүүдийн хэрэгжилт ямар ахицтай байна вэ?
		2.2. Цогц төлөвлөгөөний хэрэгжилтэд ямар хүчин зүйлс, үйл явдал нөлөөлж байна?
		2.2. Цогц төлөвлөгөөний хүрээнд хийгдсэн арга хэмжээнүүдэд ялгаатай бүлгийн хүүхдүүд хэрхэн хамрагдсан бэ?
		2.3. Цогц төлөвлөгөөний хэрэгжилтээс гарсан сайн туршлага болон сургамж юу вэ?
Тогтвортой байдал	EQ3. Орон нутаг, сургуулийн түвшинд сурагчдын хичээл, сурлагын хоцрогдлыг арилгах, тогтворжуулах тогтолцоо бүрдэж чадсан уу?	1.1. Цогц төлөвлөгөөний хэрэгжилтийг цааш үргэлжлүүлэхэд шаардлагатай нөөцүүдийг бүрдүүлж чадсан уу?
		1.2. Цогц төлөвлөгөөнөөс бий болсон сайн туршлагыг хуваалцах, таниулах ажлууд хийгдсэн үү?
		1.3. Сургууль болон орон нутагт залруулга арга хэмжээ бүхий дэмжих тогтолцоог бие даан хэрэгжүүлэх чадавхтай болсон уу?

2.3. ҮНЭЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АРГУУД

Мэдээллийн үнэн зөв байдлыг нэмэгдүүлж, харьцуулан дүн шинжилгээ хийх зорилгоор үнэлгээнд **тоон болон чанарын судалгааны** аргыг хослуулан ашиглаж, баримт бичгийн шинжилгээ, асуумж судалгаа, ганцаарчилсан ярилцлагууд зохион байгуулав.



Хүснэгт 2. Үнэлгээний мэдээлэл цуглуулах арга, зорилго, хамрах хүрээ

Мэдээлэл цуглуулах арга	Зорилго/тайлбар	Хамрах хүрээ
Баримт бичгийн шинжилгээ	Үнэлгээний тайлангийн найдвартай байдлыг нэмэгдүүлэх, нэмэлт мэдээлэл цуглуулах зорилгоор хоёрдогч эх сурвалжуудаас холбогдох баримт бичгүүдийг цуглуулан, үнэлгээний үр дүнд ашигласан.	Холбогдох баримт бичгүүд
Асуумж судалгаа	Цогц төлөвлөгөөний хэрэгжилт, хэрэгжилтийн үр дүн болон тогтвортой байдлыг үнэлэх нийт 53 асуулт бүхий асуумж зохиож, тоон мэдээлэл цуглуулсан. Цаг болон төсөв хэмнэх зорилгоор тоон асуумжийг KoboToolbox платформыг ашиглан, онлайнар зохион байгуулсан.	ЕБС-ийн багш нар
Ганцаарчилсан ярилцлага	Цогц төлөвлөгөөний хэрэгжилт, түүнд нөлөөлөх хүчин зүйлс, ач холбогдолтой болон тогтвортой байдлыг үнэлж, гүнзгийрүүлсэн мэдээлэл цуглуулах зорилгоор голлох оролцогч талуудын төлөөлөлтэй ганцаарчилсан ярилцлага зохион байгуулсан.	Цогц төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд оролцсон талуудын төлөөлөл

2.4. ҮНЭЛГЭЭНИЙ ТҮҮВРИЙН ХЭМЖЭЭ, БҮРЭЛДЭХҮҮН

2.4.1. ТООН СУДАЛГААНЫ ТҮҮВЭР

Тоон судалгаанд Монгол Улс дахь ЕБС-ийн математик, монгол хэл, уран зохиол, түүх, нийгмийн ухаан, байгалийн ухаан (физик, хими, биологи, газар зүй), бага ангийн багш нарыг хамруулна гэж үзэн түүврийн эх олонлогийг тооцов. БШУЯ-аас гаргасан статистик мэдээллээр 2022-2023 оны хичээлийн жилд дээрх хичээлийн багш нарын тоо 22,035 байсан². Уг тоонд үндэслэн дараах томъёогоор тоон судалгааны түүврийн оновчтой хэмжээг тооцсон.

$$n = \frac{Z^2 \times P_0 \times (1 - P_0)}{e^2} = 1,244$$

- z – 95 хувийн ач холбогдлын түвшин дэх t статистикийн тархалтын утга 1.96
- P_0 – түлхүүр үзүүлэлтийн хувийн жин төсөөллөөр 0.5 байхаар таамаглав
- e – таамаглаж байгаа алдааны хязгаарыг аль болох бага хэмжээтэйгээр 0.027 байхаар авав.

2 БШУЯ, <https://www.meds.gov.mn/post/124204>

Хувьсагчдын утгыг дээрх байдлаар тодорхойлж, нийт **1,244 багшийг** тоон судалгаанд хамруулав. Ингэхдээ “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн гишүүн байгууллагууд, салбар зөвлөлүүдийн үйл ажиллагаа явуулдаг зорилтот аймгуудын ЕБС-ийн багш нарыг түлхүү хамруулсан (түүврийн задаргааг Хавсралт 1-ээс харна уу). Мөн энэхүү үнэлгээ нь Ковид-19 цар тахлын үеийн нөхцөл байдлыг үнэлсэн тул 2019-2020 оны хичээлийн жилээс хойш тасралтгүй багшилж буй (доод тал нь 4 жилийн ажлын туршлагатай) багш нар судалгаанд оролцсон.


Тоон судалгаанд хамрагдсан нийт 1,244 багшийн дундаж нас нь 38 (21-64 насны хооронд) байсан ба хүйсийн хувьд дийлэнх буюу 91.6 хувь нь эмэгтэй, үлдсэн 8.4 хувь нь эрэгтэй байв. Тэдгээрийн 70.1 хувь нь хөдөө орон нутагт, 29.9 хувь Улаанбаатар хотод багшилдаг.

График 1. Судалгаанд оролцсон багш нарын байршил (n=1,244)



Харин багш нарын 69.0 хувь нь бакалавр, 31.0 хувь нь магистр болон түүнээс дээш зэргийн боловсролтой. Мэргэжлийн зэргийн хувьд 46.4 хувь нь заах арга зүйч, 34.0 хувь нь тэргүүлэх, 18.0 хувь нь зэрэггүй, 1.6 хувь нь зөвлөх зэрэгтэй байсан ба дунджаар 15 жил багшилсан туршлагатай байна (4-42 жилийн хооронд).

График 2. Багш нарын төрөл, заадаг хичээлээр (n=1,244)



2.4.2. ЧАНАРЫН СУДАЛГААНЫ ТҮҮВЭР

Цогц төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх гүнзгийрүүлсэн мэдээлэл цуглуулах зорилгоор нийт 19 хүнтэй ганцаарчилсан ярилцлага зохион байгуулав. Ганцаарчилсан ярилцлагад хамрагдсан оролцогчдын дэлгэрэнгүй мэдээллийг Хүснэгт 3-т харуулав.

Хүснэгт 3. Чанарын судалгааны түүврийн бүрэлдэхүүн

№	Оролцогчийн байгууллагаар	төрөл,	Байршил	Оролцогчийн тоо
1	БШУЯ		Улаанбаатар	1
2	Боловсролын ерөнхий газар (БЕГ)		Улаанбаатар	2
3	Боловсролын үнэлгээний төв (БҮТ)		Улаанбаатар	1
4	Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн (БСҮХ)		Улаанбаатар	1
5	Олон улсын байгууллага (ОУБ)		Улаанбаатар	2
6	Орон нутгийн Боловсрол, шинжлэх ухааны газар (БШУГ)		Өмнөговь, Дархан-уул, Баян-Өлгий, Хөвсгөл аймаг	4
7	Орон нутгийн ЕБС-ийн удирдлага		Өмнөговь, Дархан-уул, Баян-Өлгий, Хөвсгөл аймаг	8
Нийт				19

2.5. ҮНЭЛГЭЭНИЙ ХЯЗГААРЛАГДМАЛ ТАЛ, АНХААРАХ ЗҮЙЛС

Үнэлгээний багийн зүгээс дараах хязгаарлагдмал тал, анхаарах зүйлсийг тодорхойллоо. Үүнд:

- Бидний үнэлгээ хийсэн цогц төлөвлөгөө нь 3 зорилт, 10 стратеги, 62 арга хэмжээ бүхий орон даяар хэрэгжсэн, олон талуудыг хамарсан, гурван жилийн хугацаатай томоохон төлөвлөгөө байсан тул цаг хугацаа, төсөв зэрэг нөөцийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалж энд тусгагдсан бүх арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх боломжгүй байв. Түүнчлэн төлөвлөгөөний хэрэгжилтэд цогц төлөвлөгөөнд тусгасан шалгуурын дагуу 2021, 2022 оны эцэст гүйцэтгэлийн үнэлгээ хийгдээгүй, хэрэгжилтийн нэгдсэн мэдээлэл байхгүй, зарим арга хэмжээ нь хэрэгжсэн эсэх мэдээллийг нээлттэй мэдээллийн сангуудаас олж авах боломжгүй зэрэг асуудал тулгарсан. Тиймээс үнэлгээний багийн зүгээс зорилт, стратеги бүрийн хувьд аль болох хамгийн чухал, онцлох арга хэмжээнүүдийг сонгон, тэдгээртэй холбоотой тоон болон чанарын мэдээллүүдийг цуглуулж, үнэлгээг гүйцэтгэсэн болно.
- Үнэлгээний ганцаарчилсан ярилцлагад боловсролын салбарын мэргэжлийн байгууллагуудын төлөөллүүдийг хамруулсан. Гэвч тухайн байгууллагууд дотроо олон төрлийн алба, нэгжтэй бөгөөд нэгж бүр цогц төлөвлөгөөтэй холбоотой ялгаатай ажлуудыг хэрэгжүүлсэн тул ярилцлагад оролцсон оролцогч тухайн байгууллагыг бүхлээр нь

төлөөлөн мэдээлэл өгөх боломжгүй байв. Гэвч үнэлгээний багийн зүгээс аль болох олон талаас мэдээлэл авахыг зорьж, үнэлгээний тайлангийн эхний хувилбар гарсны дараа үр дүн баталгаажуулах уулзалт зохион байгуулж, тэдний саналыг сонсож, тусгасан.

- “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн гишүүн байгууллагууд, Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг ТББ-ын тусламжтайгаар тэдгээрийн үйл ажиллагаа явуулдаг сум, дүүргүүдээс дийлэнх тоон мэдээллийг цуглуулсан. Зарим аймгуудаас их, заримаас нь бага мэдээлэл цуглуулсан тул тоон судалгааны үр дүнг аймаг бүрээр ангилан харуулахад статистикийн хувьд ач холбогдолгүй. Гэвч тоон судалгааны нийт түүврийн хэмжээ нь улсын хэмжээнд төлөөлөхүйц, мөн бүс бүрийг төлөөлөхүйц Улаанбаатар, Баян-Өлгий, Хөвсгөл, Дархан-Уул, Өмнөговь, Сүхбаатар зэрэг аймгууд түүврийн бүрдлийн дийлэнх жинг эзэлсэн.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ГУРАВ. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

3.1. ЦОГЦ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЧ ХОЛБОГДОЛТОЙ, ТОХИРОМЖТОЙ БАЙДАЛ

3.1.1. ЦОГЦ ТӨЛӨВЛӨГӨӨ ЦАГ ҮЕЭ ОЛСОН, АЧ ХОЛБОГДОЛТОЙ ЭСЭХ

Төлөвлөгөө цаг үеэ олсон, ач холбогдолтой эсэх

Монгол Улсад Ковид-19 цар тахлын халдварын эрсдэл өндөр байгаатай холбогдуулан Улсын Онцгой Комиссын 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын хэмжээнд албан болон албан бус сургалтын байгууллагын үйл ажиллагааг түр зогсоох шийдвэр гаргасан³. БШУЯ-аас ЕБС-ийн сургалтын үйл ажиллагааг 2020 оны 2 дугаар сарын 3-ны өдрөөс эхлэн теле болон цахим хэлбэрээр зохион байгуулж, сурагчид 2020 онд нийт хичээлийн жилийн 47 хувь, 2021 онд 62-68 хувьтай тэнцэх хугацаанд теле болон цахим хэлбэрээр суралцсан⁴ байна.

Сургалтын үйл ажиллагаа теле болон цахим хэлбэрт шилжсэнээр боловсролын салбарт үүдэн гарсан томоохон асуудлын нэг нь сурагчдын хичээл, сурлагын хоцрогдол байв. 2020, 2021 онд хийгдсэн байгууллагуудын судалгааны үр дүнгүүдээс харахад зайны сургалтын бэлэн байдал, хүртээмж, сурагчдын оролцоо зэргээс үүдэн сурлагын хоцрогдол үүссэн байна⁵. Тухайлбал, 2021 оны 3 сард гүүгл форм ашиглан ЕБС-ийн багш нараас авсан судалгаагаар нийт багш нарын (n=1,140) 92.5 хувь нь сурагчдын хичээл, сурлагын хоцрогдол 40-50 хувьтай гэж үзжээ⁶. Энэ хугацаанд дэд бүтэц алслагдсан, интернэтгүй, цахилгаангүй зэрэг шалтгаанаас цахим сургалтад хамрагдах боломжгүй сум, багийн сургуулийн 178,577 сурагч байгааг Боловсролын хүрээлэнгийн судалгаагаар илрүүлж, сургалтын

3 НҮБ-ын Хүүхдийн сан (2020). Теле хичээлийн үр дүн, тохиромжтой байдлын үнэлгээ

4 БШУЯ (2021). Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах цогц төлөвлөгөө

5 БШУСЯ, НҮБ-ын Хүүхдийн сан, “Бүх нийт боловсролын төлөө” Иргэний нийгмийн үндэсний эвсэл, Боловсролын хүрээлэн зэрэг байгууллагуудаас гаргасан судалгааны үр дүн

6 БШУЯ (2021). Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах цогц төлөвлөгөө

материал хэвлэн хүргэж, зайнаас суралцах боломж олгосон.

БШУЯ-наас олон улсын болон дотоодын мэргэжлийн байгууллагуудын хийсэн судалгаануудын үр дүнд үндэслэж, ЕБС-ийн сурагчдын хичээл, сурлагын хоцрогдлын асуудалд анхаарал хандуулж, мэргэжлийн олон байгууллагыг хамарсан үндэсний хэмжээнд хэрэгжих бүрэн хэмжээний төлөвлөгөөг цогц байдлаар боловсруулсан нь сайшаалтай явдал болжээ. Тухайлбал, Дэлхийн Банкнаас гаргасан (2023) тайланд бага болон дунд орлоготой 60 орноос долоон орныг сонгон, тэдгээрийн сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах бодлого, үйл ажиллагаануудыг нарийвчилж судалсны нэг нь Монгол Улс байв. Тус тайланд дурдсанаар эдгээр долоон улсад хэрэгжиж буй бодлогын арга хэмжээнүүд нь (1) нотолгоонд суурилсан, (2) Засгийн газар нь удирдан зохион байгуулсан, (3) өргөн хүрээг хамарч хэрэгжсэн, (4) тухайн цаг үед үргэлжилж буй тул кэйс болгон сонгосон байна⁷. Ингэж Дэлхийн Банкнаас Монгол Улсын сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагаануудыг сайн туршлагаар сонгон судалсан нь тухайн цогц төлөвлөгөө ач холбогдолтой байсныг харуулж байна.

Боловсрол улс орны хөгжлийн тэргүүлэгч салбар тул Засгийн газраас орон нутгийн засаг захиргааны нэгжүүд, доноруудад чиглэсэн нөлөөлөл, мэдлэг ойлголт нэмэгдүүлэх ажлыг нэмэгдүүлэх шаардлагатай байдаг⁸. Харин ганцаарчилсан ярилцлагад оролцогчид энэхүү цогц төлөвлөгөө нь сурагчдын хичээл, сурлагын хоцрогдлыг улсын хэмжээнд шийдвэрлэх шаардлагатай томоохон асуудал болгосон, энэ нь оролцогч талуудыг энэ чиглэлд анхаарлаа хандуулж ажиллахад түлхэц үзүүлж, ач холбогдлыг нь олон нийт, холбогдох талуудад ойлгуулахад ихээхэн тус болсон гэж санал нэгтэй үзсэн байна.

Ковид-19 цар тахлаас үүдсэн урт хугацааны хөл хорио нь сурагчдын сурлагын амжилтад төдийгүй тэдний нийгэм, сэтгэл зүйн байдалд сөргөөр нөлөөлсөн. Тиймээс, цогц төлөвлөгөөний “Эргэн холбогдох: Сурагч, багш, эцэг эх, сургуулийн хэрэгцээг тодорхойлж, эргэн холбогдох сэтгэл зүйн орчин бүрдүүлж ажиллах” эхний зорилт нь сурагчдын нийгэм-сэтгэл зүйн хямралыг бууруулахад чиглэсэн нь төлөвлөгөөний ач холбогдлыг нэмэгдүүлж байна. Түүнчлэн, “Хичээл, сурлагын хоцрогдлыг нөхөх” буюу хоёр дахь зорилтод тэгш хамруулах сургалтыг дэмжих стратеги багтааж, хөгжлийн бэрхшээлтэй, алслагдмал орон нутгийн, ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдэд зориулсан арга

7 Дэлхийн банк (2023). Сурлагыг дэмжих, тэгш бус байдлыг бууруулах улс орнуудын хүчин чармайлтын талаарх глобал мэдээлэл.

<https://documents1.worldbank.org/curated/en/099071223174514721/pdf/P179960038bed500a08dfc0489b6fa2254a.pdf>

8 UNESCO Institute for Statistics. (2021). *School Closures and Regional Policies to Mitigate Learning Loss due to COVID-19: A Focus on the Asia-Pacific*. Montreal: UNESCO. https://uis.unesco.org/sites/default/files/documents/school_closures_and_regional_policies_to_mitigate_learning_losses_in_asia_pacific.pdf

хэмжээнүүдийг тусгасан нь хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчимтай нийцсэн байна.

Ганцаарчилсан ярилцлагад оролцсон холбогдох байгууллагуудын төлөөллүүдийн дийлэнх нь цогц төлөвлөгөөний ач холбогдлыг өндрөөр үнэлж, одоо ч төлөвлөгөөнд тусгагдсан зарим арга хэмжээнүүд ач холбогдолтой хэвээр байгааг онцолсон. Энэ удаагийн цогц төлөвлөгөөний хэрэгжих хугацаа нь гурван жил боловч сурлагын хоцрогдлыг нөхөх хэрэгцээ, шаардлага цаашид ч хэвээр байх тул энэ төрлийн цогц төлөвлөгөө, хөтөлбөр, арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатайг мөн дурдаж байв.

Энэхүү цогц төлөвлөгөө тухайн үед цаг үеэ олсон төлөвлөгөө байсан. Төлөвлөгөөнд туссан ажлууд цаашид ч ач холбогдлоо алдахгүй. Одоо ч үргэлжлүүлээд хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Баян-Өлгий аймгийн БШУГ-ын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын хэсгээс

2021 оны 2 дугаар сард Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/90 дүгээр тушаалаар цогц төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж, төлөвлөгөөг харьцангуй богино хугацаанд боловсруулж, мөн оны 5 дугаар сард сайдын А/190-р тушаалаар батлуулсан нь түргэн шуурхай, цаг үеэ олсон ажил болсон байна. Цогц төлөвлөгөө боловсруулах ажилд БШУЯ-ны хүсэлтээр Азийн Хөгжлийн Банкны “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-өөс санхүүжүүлсэн нь төлөвлөгөө боловсруулах ажлыг түргэн шуурхай зохион байгуулахад чухал дэмжлэг болсон.

Сургалтын үйл ажиллагааг хэвийн болгож, энгийн байдалд шилжүүлэх нь тухайн үедээ хамгийн гол зорилго байсан. Жилийн дотор хоцрогдол арилж, тогтворжих боломжгүй. Гэхдээ яаралтай арга хэмжээ авч 3 жилийн дотор хэрэгжүүлээгүй байсан бол хоцрогдол нь цаг минутаар хэмжигдэж, ихсэх байсан.

ОУБ-ын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын хэсгээс

3.1.2. ЦОГЦ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХАД ТАЛУУДЫН ОРОЛЦООГ ХАНГАСАН ЭСЭХ

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/90 дүгээр тушаалаар Цогц төлөвлөгөө боловсруулах 15 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдаж, тус оны 3 сарын 10-ны өдөр үйл ажиллагаагаа эхэлсэн байна. Ажлын хэсгийг Азийн хөгжлийн банк (АХБ)-ны төлөөлөл ахалж, нарийн бичгийн даргаар Боловсролын хүрээлэн (БХ)-ийн эрдэм шинжилгээний ажилтан ажилласан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд дараах байгууллагын төлөөллүүд багтсан байна.

Хүснэгт 4. Цогц төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн

№	Байгууллагын төрөл	Байгууллага	Тоо
1	Төрийн байгууллага	БШУЯ	1
		Насан туршийн боловсролын үндэсний төв (НТБҮТ)	1
		Боловсролын хүрээлэн	2
		Боловсролын мэдээллийн технологийн төв (БМТТ)	1
		Багшийн мэргэжил дээшлүүлэх институт (БМДИ) ⁹	2
		БҮТ	1
2	Олон улсын байгууллага	Азийн хөгжлийн банк	2
3	Их сургууль	Монгол Улсын Боловсролын Их Сургууль (МУБИС)	1
4	Иргэний нийгмийн байгууллага	Боловсролын реформ ТББ	1
		Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг ТББ (БХАН)	1
5	Хувь судлаач	Хувь судлаач	2
Нийт			15

Ажлын хэсгийн гишүүдийн 60 хувь нь БШУЯ болон түүний харьяа мэргэжлийн зургаан байгууллагын төлөөлөл байгаа бол үлдсэн 40 хувийг ОУБ, ИНБ, их сургуулийн төлөөлөл, хувь судлаачид бүрдүүлжээ. Цогц төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг уг төлөвлөгөө батлагдсан 2021 оны 5 дугаар сарын 02-ны өдөр хүртэл хоёр сарын хугацаанд 5 удаа танхимд хуралдаж, цахимаар 20 гаруй удаа уулзалт хийсэн байна. Цогц төлөвлөгөөг боловсруулах үйл явцад оролцсон зарим төлөөллийн дүгнэснээр Ковид-19 цар тахлын хүнд үе байсан ч төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг түргэн шуурхай, үр ашигтай хамтран ажиллаж чадсан байна.

⁹ Одоогийн Боловсролын Ерөнхий Газар

Харин ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орон нутгийн БШУГ, ЕБС-ийн төлөөлөл багш, сэтгэл зүйчдийг хамруулаагүй, тэдний дунд идэвхтэй хэлэлцүүлэг өрнүүлээгүй нь олон талын оролцоог бүрэн хангаагүй явдал болсон. Энэ байдал КОВИД-19 цар тахлын нөхцөл байдал болон богино хугацаанд төлөвлөгөөг боловсруулах шаардлагатай тулгарсан зэрэг шалтгаан нөлөөлсөн байх боломжтой. Гэвч цогц төлөвлөгөөнд тусгагдсан үндсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, сурагчидтай тулж ажиллах гол үүрэгтэй орон нутгийн БШУГ, ЕБС-ууд, багш нарын саналыг авч тусгах нь зайлшгүй шаардлагатай байсан гэж үзэж байна.

3.1.3. ЦОГЦ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭНҮҮД БОЛОН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭНИЙ ТОХИРОМЖТОЙ БАЙДАЛ

Цогц төлөвлөгөөг анх боловсруулахдаа Монгол Улсад тухайн үед хийгдсэн сурагчдын хичээл, сурлагын хоцрогдолтой холбоотой судалгаанууд болон олон улсын сайн туршлагууд дээр үндэслэж, сурагчдын суралцахуйг дэмжих тодорхой тогтолцоог санаачилсан нь сайшаалтай. Түүнчлэн цогц төлөвлөгөөний хэрэгжилтийн удирдлага, зохион байгуулалтыг хариуцах байгууллагыг тогтоож, дэмжих тогтолцоог хэрэгжүүлэх талууд болон олон нийтийн үүрэг оролцоог нарийвчлан, түвшин бүрээр тодорхой тусгасан байна.

Хичээл, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах стратеги, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд төлөвлөсөн арга хэмжээнүүдийг хэрэгжих боломжтой байсан гэж ганцаарчилсан ярилцлагад оролцогчдын олонх нь хүлээн зөвшөөрч байв. Мөн төлөвлөгөөнд туссан арга хэмжээнүүд бүрэн хэрэгжсэн ч гурван жилийн дотор сурагчдын хичээл, сурлагын хоцрогдол бүрэн арилах боломжгүй гэдэгтэй санал нийлж байсан. Хэдийгээр төлөвлөсөн хугацаанд хоцрогдлыг бүрэн арилгах боломжгүй ч тухайн үед энэ асуудлыг олон нийт, оролцогч талуудын анхааралд оруулж, нэг зорилгын төлөө мэргэжлийн байгууллага бүр тус тусын чиг үүргийн хүрээнд холбогдох үйл ажиллагаа, арга хэмжээг нэгтгэн төлөвлөсөн нь цогц төлөвлөгөөний ач холбогдлыг нэмэгдүүлсэн.

Цогц төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв бүрдүүлэхэд ОУБ-уудтай хамтран ажиллаж, тэдгээрээс санхүүгийн дэмжлэг авахаар төлөвлөгөөнд тусгасан. Мөн төлөвлөгөөний хэрэгжилтэд аймаг, нийслэл, сум, дүүргийн орон нутаг хөгжүүлэх сангийн төсвийн 10 хувийг зарцуулахаар тусгасан. Гэвч төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд жил бүр нийт хэдий хэмжээний төсөв шаардлагатай талаар, мөн улсын төсөв эсвэл БШУЯ-ны төсвийн хэдэн хувийг цогц төлөвлөгөө хэрэгжүүлэхэд зарцуулах талаар тодорхой заагаагүй байна. Орон нутгийн БШУГ болон ЕБС-иудын төлөөллүүдийн мэдээлж

буйгаар цогц төлөвлөгөөнд туссан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд хүний нөөц болон цаг хугацааны хувьд томоохон асуудал тулгараагүй ч санхүүгийн хувьд тодорхой бэрхшээлүүд тулгарч байсан байна. (Дараагийн бүлэгт дэлгэрэнгүй тайлбарласан болно.)

Цогц төлөвлөгөөнд туссан зарим үйл ажиллагааг, тухайлбал суралцахуйг дэмжих тогтолцоог, хэрэгжүүлэхэд ЕБС-ийн багш нараас ихээхэн хичээл зүтгэл, цаг хугацаа шаарддагийг тооцон дэмжигч багш, явуулын багш, дадлагажигч багш, сэтгэл зүйч, дотуур байрын багшийг нэмэлтээр ажиллуулахаар төлөвлөсөн нь хүний нөөцийн хувьд хэрэгжих боломжийг нэмэгдүүлсэн байна. (Гэвч бодит байдал дээр энэ төлөвлөгөө нь хэрэгжсэн эсэхийг дараагийн бүлгүүдэд дэлгэрэнгүй авч үзнэ.)

Аливаа бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө нь хэрэгжихүйц байхын тулд хэмжигдэхүйц шалгуур үзүүлэлттэй, харьцуулах суурь түвшинтэй байх ёстой. Энэ төлөвлөгөөнд “Цогц төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээ”-ний хэсгийг тусад нь бүлэг болгож, хэрэгжүүлэх үйл ажиллагааны 10 стратегийн бүх арга хэмжээ бүрийг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлж, бараг бүх (2.4.5 дахь арга хэмжээнээс бусад) шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшнийг 2021, 2022, 2023 оноор тодорхойлсон нь сайшаалтай байна. Ийнхүү цогц төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнүүдийг тодорхойлсон нь цогц төлөвлөгөөний үр дүнг үнэлэх, гарсан өөрчлөлт, ахицыг хэмжихэд давуу тал бий болгож байна.

Түүнчлэн, хяналт-шинжилгээ болон үнэлгээг ямар давтамжтай, хэзээ, хэн хийхийг тусгаж өгчээ. Хяналт-шинжилгээ, үнэлгээг зөвхөн төрийн байгууллага бус, ИНБ-аар хөндлөнгийн үнэлгээ хийлгэж болно гэсэн нь төлөвлөгөөний үр дүнг үнэн бодитой хэмжихэд ач холбогдолтой байна.

Үнэлгээний багт хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээтэй холбоотой дараах сул тал, хязгаарлагдмал байдал ажиглагдлаа. Үүнд:

- Зарим шалгуур үзүүлэлтийн хувьд суурь түвшнийг тодорхойлоогүй байна.
- Шалгуур үзүүлэлт бүрийн хүрэх түвшнийг тоогоор илэрхийлэх боломжтой ч жендерээр задалсан зорилтот түвшин байхгүй байна.
- Шалгуур үзүүлэлт бүрийн хувьд мэдээллийн эх үүсвэрийг тодорхойлоогүй байна.
- Ярилцлагад орсон төлөөллүүд зарим шалгуур үзүүлэлтүүдийг хэмжихэд төвөгтэй, тохиромжгүй байна гэж үзэж байв.

3.1.4. ЦОГЦ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨЛӨВЛӨЛТИЙН УЯЛДААТАЙ БАЙДАЛ

Монгол Улсын болон боловсролын салбарын хөгжлийг тодорхойлсон бодлогын баримт бичгүүдэд чанартай боловсрол эзэмших боломж бүрдүүлэх, сургалт үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэх зорилго, зорилтыг дэвшүүлсэн байна. Тухайлбал,

- “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 2.1-т “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлэх” зорилт дэвшүүлж, 2030 он хүртэлх хугацаанд хүрэх үр дүнг “Иргэн бүрд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлэн, тэгш хамруулж, бүх шатны боловсролын залгамж холбоог хангаж, сургалт, үйл ажиллагааны чанарыг дээшлүүлсэн байна” гэж тодорхойлжээ.
- “Боловсролын салбарыг хөгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөө /2021-2030 он/-ний 2.2 “Бага, дунд боловсрол” бүлгийн Зорилт 3.1 (Чанар): “Бага, дунд боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах зорилт дэвшүүлж, 2030 он хүртэлх хугацаанд хүрэх үр дүнг “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурлагын амжилтад ахиц гарч, хот, хөдөөгийн сурагчдын үнэлгээний гүйцэтгэлийн ялгаа багассан байна” гэж тодорхойлжээ. Мөн бүлгийн Зорилт 3.2 (Хүртээмж): Хөгжлийн онцлогоос үл хамааран суралцагчийн бага, дунд боловсролын үйлчилгээнд тэгш хамрагдах боломжийг нэмэгдүүлэх зорилт дэвшүүлж, хүрэх үр дүнг “Газар зүйн байршил, нийгэм эдийн засгийн нөхцөл, хөгжлийн онцлог, ялгаатай байдлаас үл хамааран бага, дунд боловсролын чанартай үйлчилгээнд бүрэн хамрагдсан байна” гэсэн байна.
- “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” болон “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлэх” зорилго дэвшүүлсэн байна. Үүнд 2.3.12. Цахим сургалтын платформыг хөгжүүлж, цахим сургалтын хөтөлбөрийг боловсруулан, цахим агуулга, цахим хичээл боловсруулан бүх насны иргэдэд насан туршдаа суралцахуйг дэмжих боломжийг бүрдүүлэх зорилт багтжээ.
- “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого 2014-2024” баримт бичигт “2.1.1. Иргэн бүрд үзүүлэх боловсролын үйлчилгээ нь олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц чанартай, хүртээмжтэй байх” гэжээ.

Эдгээрээс үзэхэд цогц төлөвлөгөө нь Монгол Улсын хөгжлийн болон боловсролын салбарын богино, дунд, урт хугацааны бодлогын баримт бичгүүдтэй сайн уялдсан байна.

Түүнчлэн, цогц төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр БШУЯ-ны газар, хэлтсийн дарга нарт, (энэ уулзалт нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгүүдийн санал зөвлөмжийг Боловсролын ерөнхий хууль, түүнийг дагалдан гарах хуулиудын шинэчилсэн найруулгын төсөлд тусгуулах, боловсролын салбарын богино, дунд хугацааны бодлого, төлөвлөлттэй уялдуулах зорилготой байжээ); 2021 оны 24-ний өдөр цогц төлөвлөгөөг цахим хэлбэрээр БШУЯ, харьяа мэргэжлийн байгууллагууд, аймгуудын БШУГ, сургуулиудын удирдах ажилтан, багш, эцэг эхийн төлөөлөлд танилцуулсан.

3.2. ҮР ДҮНТЭЙ, ҮР АШИГТАЙ БАЙДАЛ

Цогц төлөвлөгөөг 3 жилийн хугацаанд буюу 2021-2022, 2022-2023, 2023-2024 оны хичээлийн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Энэхүү үнэлгээ нь 2023 оны 10 дугаар сард эхэлсэн тул эхний хоёр жилийн буюу “Зорилт 1. Эргэн холбогдох”, “Зорилт 2. Хичээл, сурлагын хоцрогдлыг нөхөх”-т туссан арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэхэд гол анхаарлаа хандуулсан.

Аливаа үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг үнэлэхэд анхны зорилтын гүйцэтгэл хэр ахицтай байгааг хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээнд тусгагдсан зорилтот түвшинд үндэслэн тодруулдаг. Үүний дагуу үнэлгээний багаас цогц төлөвлөгөөний хэрэгжилтийн 2021, 2022 оны жилийн эцсийн үнэлгээний үр дүн, тайлантай танилцахаар “Бүх нийт боловсролын төлөө” Иргэний нийгмийн үндэсний эвслээр дамжуулан БШУЯ-нд албан бичиг хүргүүлсэн боловч энэ тодорхой хариу өгөөгүй билээ. Тиймээс цогц төлөвлөгөөний үр дүнтэй байдлыг үнэлэхдээ үнэлгээний багийн цуглуулсан тоон болон чанарын мэдээлэлд үндэслэсэн. Үнэлгээний багт цогц төлөвлөгөөнд тусгагдсан 10 стратеги, үүний хүрээнд төлөвлөсөн арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн мэдээллийг бүрэн цуглуулах хангалттай нөөц, бололцоо байхгүй тул голлох арга хэмжээнүүдийн хүрээнд үнэлгээний үр дүн боловсруулагдсан болохыг дурдах нь зүйтэй.

3.2.1 ЦОГЦ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЛААРХ ТАЛУУДЫН ОЙЛГОЛТ

Цогц төлөвлөгөөнд туссан арга хэмжээнүүд үр дүнтэй хэрэгжихэд оролцогч талууд, ялангуяа төлөвлөгөөг хэрэгжүүлж, сурагчидтай ажиллах ЕБС-иудын удирдлага, багш нар тухайн төлөвлөгөөний талаар нэгдсэн ойлголт, мэдлэгтэй байх шаардлагатай. Тоон судалгаанд оролцсон нийт багш нарын 90.0 хувь нь цогц төлөвлөгөөний талаар мэднэ гэж хариулсан


бол үлдсэн 10.0 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Багш нар төлөвлөгөөний талаарх мэдээллийг голчлон сургуулийн захиргаа (36.9%), орон нутгийн БШУГ (25.7%), БШУЯ эсвэл БЕГ (19.2%)-аас авсан байна.

Багш нарын цогц төлөвлөгөөний талаарх мэдлэгээ үнэлсэн байдлыг харахад ихэнх хувь нь өөрсдийгөө төлөвлөгөөний талаар тодорхой, цэгцтэй ойлголттой (45.1%), зорилго, ажлын хүрээний хувьд л мэднэ (35.5%) гэжээ. Хариултыг хот, хөдөөгөөр ялган авч үзэхэд төдийлөн ач холбогдолтой ялгаа ажиглагдахгүй байна.

Дээрх үр дүнгүүдээс харахад ЕБС-иудын багш нарын цогц төлөвлөгөөний талаарх ойлголт боломжийн түвшинд байна. Хэдий зарим багш цогц төлөвлөгөөтэй бүрэн танилцаагүй, эсвэл үүний албан ёсны нэршлийг нь мэдэхгүй байж болох ч доторх арга хэмжээнүүдийг ажил үүргийнхээ дагуу хэрэгжүүлдэг байх боломжтой.

График 3. Цогц төлөвлөгөөний талаарх мэдлэг, ойлголт

График 3. Цогц төлөвлөгөөний талаарх мэдлэг, ойлголт



Харин ганцаарчилсан ярилцлагад оролцсон мэргэжлийн байгууллагын төлөөллүүд болон ЕБС-ийн удирдлагууд бүгд өөрсдийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд цогц төлөвлөгөөний талаар сайн мэднэ гэдгээ илэрхийлж байв. Энэ нь ч тэдний ярилцлагын үеэр өгч байсан нарийн мэдээллүүдээс анзаарагдсан.

3.2.2. “ЭРГЭН ХОЛБОГДОХ” БУЮУ НЭГДҮГЭЭР ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТ

“Эргэх холбогдох” зорилтын хүрээнд “Сурагч, багш, эцэг эх, сургуулийн хэрэгцээг тодорхойлж, эргэн холбогдох сэтгэл зүйн орчин бүрдүүлж ажиллах” зорилго тавьсан байна. Тухайн зорилт нь дотроо дараах гурван стратегитай. Үүнд:

1. Сурагч, багш, эцэг эхийн эргэн холбогдох боломжит сувгуудыг ашиглах;

2. Сурагч, багш, сургуулийн хэрэгцээнд үндэслэн арга замаа тодорхойлох;
3. Сургууль, гэр бүлд сурагчийг дэмжих нийгэм, сэтгэл зүйн эерэг орчин бүрдүүлэх.

Нэгдүгээр зорилтын хэрэгжилтийг стратеги тус бүрийн хувьд үнэлэх доорх үр дүн гарлаа.

Стратеги 1.1. Сурагч, багш, эцэг эхийн эргэн холбогдох боломжит сувгуудыг ашиглах

Ковид-19 цар тахлын хөл хорионы үе буюу танхимын хичээл эхлээгүй байх үед сургууль бүр сурагчид болон тэдгээрийн гэр бүлтэй харилцаа холбоо тогтоох, цахим болон теле хичээлийн чанарыг нэмэгдүүлэхэд дор бүрнээ анхаарч, ялгаатай арга барилууд ашигласан байна. Тухайлбал зарим сургууль судалгаа хийж, сургуульдаа ирж, хичээлд орж чадахгүй байгаа сурагчдын шалтгааныг тодруулж, тэдгээрт тохирсон арга хэмжээнүүд хэрэгжүүлжээ.

Даалгавраа цаасан хэлбэрээр боловсруулж, чиглэл чиглэлээр 5 багт байдаг сурагчдад хүргүүлж, тодорхой хугацааны дараа очиж даалгавраа шалгаад, дахиж нэмэлт даалгавар өгөх зэргээр эргэх холбоотой байсан. Алслагдсан 5 багт багш нар сургуулийн удирдлагуудтай хамтран 5 баг болж ажиллаж байсан.

Баян-Өлгий аймгийн ЕБС-ийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагын хэсгээс

2020-2021 оны II улирлын хичээл, сургалтын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах хүрээнд БШУЯ-аас багш нарын “Мэргэжлийн бүлэг”-ийг үүсгэн, цахим хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд тус хэлэлцүүлгийн дараа Боловсролын хүрээлэнгийн сургалтын хөтөлбөрийн судалгаа хариуцсан эрдэм шинжилгээний ажилтнуудын чиглүүлэг дор БШУГ-ууд орон нутгийнхаа түвшинд сургууль бүрийн мэргэжлийн багш нарын бүлгийг цахим орчинд үүсгэн тэдэнд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг хэрэгжүүлж ажиллажээ. Ийнхүү мэргэжлийн бүлгийн зохион байгуулалтад шилжсэнээр сургууль, орон нутгийн түвшинд багш нар багшлахуйд тулгамдаж байгаа асуудлаа хамтран шийдвэрлэх, харилцан бие биеэ хөгжүүлэх, мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломж бий болгосон төдийгүй КОВИД-19 цар тахлаас үүдэлтэй хичээл сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах зорилгоор алслагдсан бүс нутагт амьдардаг сурагчдад шаардлагатай сургалтын багц хүргэж, холбоо тогтоон ажилласан.

Багшийн мэргэжлийн хөгжлийн бүлэг нь багш ажлын байрандаа тасралтгүй хөгжих оновчтой шийдэл болж 1990-ээд оноос хойш дэлхийн

олон улс орнуудад эрчимтэй хөгжиж байгаа бөгөөд өнөө үед боловсролын хөгжилд хувь нэмэр оруулж буй шинэлэг санаануудын нэг болж, багшийн тасралтгүй хөгжлийн үржил шимт хөрс гэж хүлээн зөвшөөрөгдөх болж байна. Сургуулийн багшийн мэргэжлийн хөгжлийн бүлгийн хөгжлийн асуудлыг судалсан бүтээл олон улсад цөөнгүй гарсны зэрэгцээ ийм бүлэг ажиллах эрх зүйн орчин манай улсад ч бүрдсэн гэж үзэж болохоор байна. Тухайлбал, Алсын хараа 2050, Монгол Улсын Засгийн газрын “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай” 2022 оны 91 дүгээр тогтоолыг үндэслэн мөн онд БЕГ-ын дарга “Заавар батлах тухай” 170 дугаар тушаалыг баталсан. Энэ тушаалын хоёрдугаар хавсралтад багшийн тасралтгүй хөгжлийг хангахад чиглэсэн сургалтын зардлын төсвийн 60 хувийг багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих сургалт /1.8.1/, 40 хүртэл хувийг багшийн хөгжлийг дэмжих бусад үйл ажиллагаа /1.8.2/-нд зарцуулахаар хуваарилсан бөгөөд сургуулиудын мэргэжлийн бүлгийн үйл ажиллагааны зардлыг энэхүү 40 хувиас санхүүжүүлэх боломжтой болсон. Гэхдээ зарим газарт мэргэжлийн бүлгийн үйл ажиллагааны санхүүжилтийг төрийн сан бүрэн олгохгүй байгаа бэрхшээл үүсгэж байгаа аж.

Сургуулиуд тухайн орон нутаг, цаг үеийнхээ онцлогт тохируулж, сурагчдад даалгавар, нэмэлт материал хүргүүлэхдээ такси, орон нутгийн тээврээр дамжуулах, хүнсний дэлгүүр, эмнэлэг зэрэг байгууллагуудад байршуулах, сум, орон нутгийн удирдлагуудтай хамтран түгээх зэргээр хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарсан байна. Зарим багш нар сурагчдын эцэг эхтэй биечлэн уулзах, гэрээр очиж БСҮХ-ээс гаргасан “Бие даан суралцах ажлын дэвтэр”-ийг сурагчдад тараан, ажиллуулж байжээ. Түүнчлэн, сургуулиуд сурагчид, тэдгээрийн гэр бүлтэй утсаар болон цахимаар холбогдож, харилцаа холбоогоо таслахгүй байхад анхаарсан байна.

Сургалтын үйл ажиллагаанаас хөндийрсөн сурагчдыг мэдлэг, мэдээллээр хангах зорилгоор бие даан ажиллах дасгал ажлын дэвтэр боловсруулж, орон нутгуудад түгээсэн. Зарим аймгууд “Витаминтай цүнх” зэргээр нэрлэж, сурагчдад янз бүрийн аргаар тараасан байсан.

ОУБ-ийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагын хэсгээс

Цогц төлөвлөгөөнд хичээл эхлэх үед сэтгэл зүйн эерэг орчин бүрдүүлэх, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах "Ногоон гэрэл" үйл ажиллагааны удирдамж боловсруулна гэж заасан. БСҮХ-ээс тус удирдамжийг Азийн Хөгжлийн Банкны тусламжтайгаар боловсруулж, олон нийтэд нээлттэй байдлаар цахим орчинд байршуулан¹⁰, ЕБС-иудын удирдлагуудад танилцуулсан байна.

10 <https://s3.ap-southeast-1.amazonaws.com/assets.aplus.mn/h/1-4-new2.pdf>

БМДИ нь чиг үүргийнхээ дагуу 2021 оны 8-р сард үндэсний хэмжээнд зохион байгуулдаг төрөлжсөн сургалтаа “Сурагчдын сурлагын хоцрогдлыг арилгахад дэмжлэг үзүүлэх” сэдвээр цахим хэлбэрээр зохион байгуулж, 48,000 гаруй багш, ажилтныг хамруулсан бөгөөд “Ногоон гэрэл” үйл ажиллагааны удирдамжийг нийт сургууль, багш нарт танилцуулсан байна

Харин энэ удирдамжийг сургууль болгон ашигласан эсэх болон хэрхэн ашигласан талаар нарийн мэдээлэл одоогоор байхгүй байна. Харин ганцаарчилсан ярилцлагад оролцсон Баян-Өлгий болон Өмнөговь аймгийн ЕБС-ийн удирдах албан тушаалтнууд “Ногоон гэрэл” удирдамжийн дагуу төлөвлөгөө гаргаж, сэтгэл зүйн эерэг, таатай орчин бүрдүүлэхэд өөрсдийн хэмжээнд боломжийн ажилласан гэж мэдэгдсэн.

Зураг 1. "Ногоон гэрэл" үйл ажиллагааны удирдамж



ГАРЧИГ

"НОГООН ГЭРЭЛ" ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ	3
Оролт	3
Ногоон гэрэл үйл ажиллагааны зорилго, зорилтууд	4
Ногоон гэрэл үйл ажиллагаанд баримтлах зарчим	4
Ногоон гэрэл үйл ажиллагааны удирдамжийн агуулга	5
"Ногоон гэрэл" үйл ажиллагааны хэрэгжилтийг хянах хуудас	12
НИЙГЭМШИЛ, СЭТГЭЛ ЗҮЙ, ЭРҮҮЛ АХУЙН ЗӨВЛӨМЖ	15
Цар тахлын болон хөл хорионы үе дэх хүүхдийн сэтгэл зүйн асуудлууд	15
Балы, сэтгэл нүүрхүүлэгчдэд	16
Цаг зуурагд өгөх зөвлөмж	43
Сурагчдад өгөх зургууд ахуйн зөвлөмж	46
НОМ ЭГНЭ	48

Сурагчид сургуулиасаа нэлээд хөндийрсөн байдалтай ирсэн тул “Ногоон гэрэл” төлөвлөгөө гаргаж, хүүхдүүдийн сэтгэл зүйд эергээр нөлөөлөх, анги хамт олонд таатай уур амьсгал бүрдүүлэх ажлууд зохион байгуулсан. Багш бүр өөрсдийн хийсэн төлөвлөгөөний дагуу сурагч бүрдээ хүрч ажилласан.


Өмнөговь аймгийн ЕБС-ийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагын хэсгээс

оношилгооны тайланг бусад байгууллагуудтай хуваалцдаггүй талаар шүүмжлэх тохиолдол байсан.

Стратеги 1.3. Сургууль, гэр бүлд сурагчийг дэмжих нийгэм, сэтгэл зүйн зэрэг орчин бүрдүүлэх

Үнэлгээний багийн зүгээс багш нараас Ковид-19 цар тахлын дараа сурагчид сургуульдаа дасан зохицох, дахин хөндийрөхгүй байхад чиглэсэн нийгэм-сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа зохион байгуулсан эсэхийг тодруулахад нийт багш нарын 62.6 хувь нь тийм, 19.9 хувь нь үгүй, 17.5 хувь нь мэдэхгүй гэж хариулсан. Багш нарын өгсөн хариултад хот, хөдөөгөөс хамаарсан хамаарал байгаа эсэхийг хи-квадрат тестээр шалгахад ялгаатай байдал ($\chi^2(2, N=1,244) = 8.7, p > .05$) ажиглагдсан ба Улаанбаатар хотын багш нар илүү “тийм” гэсэн хариултыг өгсөн байна.

График 5. Сурагчдад нийгэм-сэтгэлзүйн дэмжлэг үзүүлсэн эсэх, байршлаар (n=1,244)



Харин “тийм” гэж хариулсан багш нараас ямар дэмжлэг үзүүлж байсныг тодруулахад “Сургуулийн эмч, нийгмийн ажилтан нар шаардлагатай сурагчдын эцэг, эх болон сум, хорооны нийгмийн ажилтантай хамтран ажилласан (48.4%)” болон “Сургуульд ээрсэтгэл зүйч ажиллаж, шаардлагатай сурагч, тэдний эцэг эхэд сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлсэн (45.7%)” ажлууд илүү түгээмэл байна. Харин явуулын сэтгэл зүйч ажиллуулсан тохиолдол хамгийн бага (9.9%) буюу хэрэгжилт хангалтгүй байна. Ярилцлагад оролцсон төлөөллүүд мөн явуулын сэтгэл зүйч ажиллуулсан байдал хангалтгүй талаар дурдаж байсан.

Эдгээр хариулт нь хот, хөдөөгийн байршлаас хамаарч ялгаатай байгаа эсэхийг шалгахад зарим үйл ажиллагааны хувьд статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа ажиглагдсан. Тухайлбал, “Сургууль дээр сэтгэл зүйч ажиллаж, шаардлагатай сурагч, тэдний эцэг эхэд сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлсэн ($\chi^2(1, N=779) = 39.4, p > .001$)” үйл ажиллагаа Улаанбаатар хотын багш нар дунд түгээмэл байгаа бол “Багш нар сурагчдын гэрт очиж, тэдэнд болон эцэг эхэд нь сэтгэл зүйн дэмжлэг үзүүлсэн ($\chi^2(1, N=779) = 49.7, p > .001$)” ажил хөдөө, орон нутгийн багш нарын дунд түгээмэл байна.


График 4. Сурагчдын нийгэм-сэтгэлзүйн байдлыг дэмжихэд зориулж зохион байгуулсан үйл ажиллагаанууд (олон сонголттой, n=779)



Дээрх асуултад “бусад” гэж хариулсан багш нарын хариултыг задалж харахад сургалтын орчныг сайжруулах ажлууд, заах арга нэгдлийн өдөрлөг зохион байгуулах, сурагчдад цахимаар зөвлөгөө өгөх, ярилцах, сурагчдыг сургуульдаа дуртай болгох зорилгоор сарын аян өрнүүлэх зэрэг ажлуудыг дурдсан байна.

Түүнчлэн багш нараас дээр дурдсан ажлууд хэр үр дүнтэй байсныг тодруулахад бүх ажил дундаж болон түүнээс дээш үр дүнтэй байсан нь судалгааны үр дүнгээс харагдсан.

График 5. Сурагчдын нийгэм-сэтгэлзүйн байдлыг дэмжихэд зориулж зохион байгуулсан үйл ажиллагаануудын үр дүн



“Сургууль, гэр бүлд сурагчийг дэмжих нийгэм, сэтгэл зүйн эерэг орчин бүрдүүлэх” стратегийн хүрээнд төлөвлөсөн гол ажлуудын нэг нь сурагчдад сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлэх, сургуулийн болон явуулын сэтгэл зүйч

ажиллуулах явдал байсан. Дээрх асуулгын үр дүнгээс харахад Улаанбаатар хотын сургуулиуд хөдөө орон нутгийн сургуулиудаас илүү сэтгэл зүйчдийг ажиллуулсан байна. Мөн явуулын сэтгэл зүйч ажиллуулсан тохиолдол Улаанбаатар хотод ч, хөдөө орон нутагт ч маш бага байна.

Сургуулийн сэтгэл зүйч бэлтгэх, ажиллуулах үйл ажиллагаанд ШХА идэвхтэй оролцож, 2021 оны зун 60 орчим сэтгэл зүйчийг бэлтгэж, ЕБС-иудад анх удаа сэтгэл зүйчдийг ажиллуулж эхэлсэн байна. Харин 2021-2022 оны хичээлийн жилд нийт 151 сэтгэл зүйч ЕБС-д ажилласан байна¹¹. Эндээс харахад сэтгэл зүйч бэлтгэн, ажиллуулах цогц төлөвлөгөөний зорилтын биелэлт анхны зорилтоо (2021 онд 250, 2022 онд 550 сэтгэл зүйч ажиллуулах) биелүүлээгүй ч тодорхой үр дүнд хүрсэн байна. Харин сэтгэл зүйчгүй сургуулиудын хувьд анги удирдсан багш, нийгмийн ажилтан, эцэг эхийн зөвлөлөөр дамжуулж сурагчдын сэтгэл зүйг дэмжихийн тулд гэрээр нь зочлох, тусгайлсан аян зохион байгуулах зэрэг үйл ажиллагаанууд хэрэгжүүлж байсныг судалгаанд оролцсон ЕБС-иудийн төлөөллүүд мэдэгдэж байсан.

Ярилцлагын үеэр гарч ирсэн нэг сайн жишээ нь ШХА-ын санхүүжүүлж БҮТ, БСҮХ-тэй хамтран хэрэгжүүлсэн “Чатбокс сэтгэл зүйн зөвлөгөө” үйлчилгээ юм. Тус ажлын хүрээнд Ковид-19 цар тахлын үед ЕБС-ийн 12-р анги төгсөгчдийн элсэлтийн ерөнхий шалгалтын өмнөх стресс менежмент, сэтгэл зүйн бэлтгэлд дэмжлэг үзүүлэх зорилгоор мэргэжлийн сэтгэл зүйчдийг чатбот дээр ажиллуулсан байна. Ингэхдээ 2021 оны 05-р сарын 24-ний өдрөөс 06-р сарын 24-ний өдрийн хооронд өдөр бүр 10:00 – 22:00 цаг хүртэл БҮТ-ийн чатботыг ажиллуулж, тусламж хүссэн сурагчдад сэтгэл зүйн дэмжлэг үзүүлжээ¹².

Дээрх мэдээллүүдээс харахад цогц төлөвлөгөөний “Эргэн холбогдох” зорилтын хүрээнд төлөвлөгдсөн ажлууд тодорхой түвшинд хэрэгжсэн байна. Хэдий төлөвлөгөөнд туссан явуулын сэтгэл зүйч ажиллуулах зэрэг зарим арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй ч ЕБС-ууд болон багш нар сурагчдын нийгэм, сэтгэлзүйн байдлыг дэмжихийн тулд өөр өөрсдийн ялгаатай аргуудыг ашиглаж, тодорхой үр дүнгүүд гаргажээ. Ярилцлагын үеэр энэхүү зорилтыг биелүүлэхэд ажиглагдсан эерэг болон сөрөг зүйлсийг тодруулахад оролцогчид дараах зүйлсийг дурдаж байв.

11 <https://montsame.mn/mn/read/303754>

12 <https://eec.mn/post/1775>

Эерэг зүйлс:

- Олон байгууллагын хүүхдэд хандах хандлага өөрчлөгдөж, салбар дундын хамтын ажиллагаа сайжирсан (Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Цагдаагийн газар, ЕБС гэх мэт).
- Зарим эцэг эхчүүд багш нартай байнга холбоотой байж, сурагчдаар даалгавар хийлгэхэд тусалж байсан.
- Эцэг эхчүүдийн сургуульд хандах хандлага, оролцоо сайжирсан.
- Ковид-19 цар тахлын дараа танхимын сургалт хичээллэж эхлэхэд сурагчдын дунд завсардалт гараагүй.
- Сурагчдын анги танхимдаа буцаж ирэх үеийн сэтгэл ханамж сайн байсан.
- Алслагдсан бүсэд амьдардаг ч даалгавар авъя, даалгавраа шалгуулъя гэж багш нарыг зорин ирдэг хүүхдүүд байсан.
- Судалгаа мэдээллийн олон сантай болсон.
- Аймаг, орон нутгийн удирдлагууд хамтран ажиллаж, шаардлагатай тохиолдолд санхүүгийн дэмжлэг үзүүлж байсан.
- Цогц төлөвлөгөө бодлогын хувьд чиглүүлэгч болж байсан.
- Зарим эцэг, эхчүүдийн хүүхдүүдээ хөгжүүлэх санаачилга нэмэгдэж, огт гишүүнгүй байдаг байсан биеийн тамирын дугуйлангуудад хамрагдах сурагчдын тоо нэмэгдсэн.

Сөрөг зүйлс:

- Алслагдмал бүсэд амьдардаг сурагчдад хүрч ажиллахад санхүүгийн бэрхшээл тулгарч байсан.
- Зарим сурагчидтай холбоо тогтооход интернэт сүлжээний асуудал тулгарч байсан.
- Асран хамгаалагч нь архины хамааралтай зэрэг маргинал сурагчдад хүрч ажиллахад бэрхшээлтэй байсан.
- Эцэг эхийн хандлага, хүүхдүүддээ тавих анхаарал, идэвхээс шалтгаалж эцэг эх, сургуулийн хамтын ажиллагаа тааруу байх нөхцөл үүсэж байсан. Тухайлбал зарим эцэг эх хүүхдүүд нь эрүүл байвал сурах үйл явц хамаагүй гэж хэлж байсан.
- Зарим сургуулийн багш, удирдах ажилтны хандлага, ёс зүй тааруу, хариуцлага хүлээх чадвар сул байсан.

3.2.3. “ХИЧЭЭЛ, СУРЛАГЫН ХОЦРОГДЛЫГ НӨХӨХ” БУЮУ ХОЁРДУГААР ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТ

“Хичээл, сурлагын хоцрогдлыг нөхөх” зорилтын хүрээнд “Хосолсон сургалтын дэд бүтэц, цахим сан бүрдүүлж, тэгш хамруулах зорилго бүхий суралцахуйг дэмжих тогтолцоог хэрэгжүүлэх, өөрийн удирдлагатай сургалтын арга зүйг нэвтрүүлэх” зорилго тавьсан байна. Тухайн зорилт нь дотроо дараах таван стратегитай. Үүнд:

1. Хосолсон сургалтын дэд бүтэц, цахим сан бүрдүүлэх;
2. Суралцахуйг дэмжих тогтолцоог хэрэгжүүлэх (дэмжигч багш, явуулын сэтгэл зүйч);
3. Явцын үнэлгээний өгөгдөлд суурилсан идэвхтэй суралцахуйг хэрэгжүүлэх;
4. Өөрийн удирдлагатай суралцахуйг дэмжсэн, хосолсон сургалтын арга зүйг хөгжүүлэх;
5. Тэгш хамруулах сургалтыг дэмжих.

Хоёрдугаар зорилтын хэрэгжилтийг стратеги тус бүрийн хувьд үнэлэхэд доорх үр дүн гарлаа.

Стратеги 2.1. Хосолсон сургалтын дэд бүтэц, цахим сан бүрдүүлэх


Хосолсон сургалтын дэд бүтцийг сайжруулах чиглэлээр БҮТ голчлон ажилласан байна. 2021 онд 3,284 теле хичээл, 50 цахим контент боловсруулж, орон даяар сурагчдад хүргэж ажиллажээ. Боловсролын мэдээллийн технологийн төвийн вэбсайтад 15,400 ээлжит хичээлийг, arlus.mn цахим платформ дээр 75 сэдвээр 577 багшийн 2,775 цагийн хичээлийг байршуулж, сурагчдад түгээсэн байна¹³.

Цаашилбал, 2021-2022 оны хичээлийн жилд “Сургалтад ашиглах нээлттэй нөөц материал, цахим агуулгыг бий болгох” ажлын хүрээнд Medle.mn цахим платформд 1-12 дугаар ангийн сурагчдад зориулсан 15,000 орчим хичээлийн контент нээлттэй байршсан байна. Одоо ч тус платформын сургалтын санг арвижуулах, хөгжүүлэх ажлууд тасралтгүй хийгдэж, сурагчдад зориулсан интерактив контентуудыг ЕБС-ийн багш нар өөрсдөө боловсруулан, түгээж байна. Мөн багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалтын зохион байгуулах, сурагчдыг сургалтын материалаар хангах зэрэг зорилгоор Moodle платформ, esurgalt.itpd.mn, ebatlamj.agency.edu.mn, bagsh.edu.mn зэрэг өөр олон цахим сангуудыг бий болгожээ. Ганцаарчилсан ярилцлагад оролцсон зарим ЕБС-ийн төлөөллүүд Medle.mn зэрэг цахим платформ ашиглан мэдээллийн сан бий болгосон талаараа дурдаж байсан. Энэ мэтчилэн цахим болон теле хичээлийн сан бий болгож, хичээлийн

13 БСҮХ-ийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

агуулгыг олон төрлөөр (видео, интерактив видео гэх мэт) түгээхэд хичээл зүтгэлтэй ажиллажээ.

Зураг 2. Сургалтын цахим платформууд



Түүнчлэн, ЕБС-иуд БШУЯ, олон улсын байгууллага, орон нутгийн захиргаа, эцэг эхийн тусламжтайгаар анги танхимуудаа ухаалаг төхөөрөмжөөр тоноглож, интернэтийн хурдаа сайжруулсан байна. 2022 онд Засгийн газрын тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаалаар ЕБС-иудын хувьсах зардлын бүрэлдэхүүнд сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний нөхөн хангалтын зардлыг тусгаж, сургууль бүрд нөхөн хангалтын зардлыг хуваарилсан байна. Ингэснээр сургууль бүр өөрсдөө шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгаа хийж, батлагдсан төсвийн хүрээнд бие даан худалдан авалт хийх боломж бий болжээ. Тиймээс сургуулиуд хосолсон сургалтын дэд бүтцээ сайжруулах зорилгоор тухайн зардлын хүрээнд хуваарилагдсан хөрөнгөөр шаардлагатай тоног төхөөрөмжүүд худалдан авсан.

БШУЯ-ны мэдээлснээр 2023 оны байдлаар Боловсролын цахим шилжилтийн хүрээнд сургууль бүрд тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардал олгосноор сургууль тус бүр цахим ангитай болж, 10-11-р ангийн сурагчид “Medle” цахим сургуулиар сонгон судлах хичээлээ байршлаас үл хамааран өөрийн сонголтын дагуу судалж байна. Тус цахим сургуульд нийслэл, аймгийн төвийн 233, сумын 234, багийн 7, нийт 475 сургуулийн 15265 сурагч суралцаж байгаа аж.

Тоон судалгаанд хамрагдсан багш нарын 36.4 хувь нь өөрсдийн сургуульд нь хосолсон сургалтын дэд бүтэц, цахим сан бүрдсэн гэдэгтэй санал нийлж байсан бол 44.0 хувь дундаж, 19.6 хувь нь санал нийлэхгүй байна гэж үзжээ. Харин нийт багш нарын 25.2 хувь нь цахим сургалтын платформ ашиглан сургалт зохион байгуулах “бүрэн чадамжтай” гэсэн бол 60.6 хувь нь “бүх функцийг нь бүрэн ашиглаж чадахгүй ч шаардлагатай тохиолдолд сургалт зохион байгуулж чадна”, 14.2 хувь нь “бие даан сургалт зохион байгуулж чадахгүй” гэж хариулсан. Багш нарынхаа хосолсон сургалт явуулах чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор Хөвсгөл аймгийн ЕБС уралдаан зохион байгуулсан зэрэг ажлууд мөн зохион байгуулагджээ.

Ковид-19 цар тахлын улмаас танхимын сургалтыг зогсоон сургалтын үйл ажиллагааг теле болон цахим хэлбэрээр явуулж эхлэхэд багш нарын өмнө тулгамдсан томоохон асуудлын нэг нь цахим төхөөрөмжийн хүрэлцээ, хүртээмжийн асуудал байв. Хамгийн сүүлд 2015 онд Засгийн газраас баталсан “Зөв Монгол хүүхэд” үндэсний хөтөлбөрийн хүрээнд бүх багшийг зөөврийн компьютероор хангасан ч үүнээс хойш цахим төхөөрөмжийг улс орондаяар шинэчилсэн тохиолдол байхгүй байна. Харин цогц төлөвлөгөөний энэхүү стратегид 2023 хүртэл бүх багш нарыг зөөврийн компьютероор хангана гэж заасан ч санхүүгийн бэрхшээлээс шалтгаалж энэ ажил бүрэн хэрэгжээгүй болохыг ганцаарчилсан ярилцлагад хамрагдсан талууд хүлээн зөвшөөрч байв.

Багш нарыг зөөврийн компьютероор хангах асуудлыг тухайн үед маш хурцаар тавьж байсан. Хичээл сургалт цахимаар явагдаж байсан тэр үед багш нар 2015 оны үед авч байсан Lenovo-тайгаа байсан. Тэр нь бүрэн ажиллахаа больчихсон байсан. Тийм л тоног төхөөрөмжтэй цахим болон теле хичээлийг эхлүүлж байлаа. Энэ нь багш нарын ажлаыг удаашруулж, чанарыг бууруулна гэж үзэж, тухайн үед нэлээн ярилцаж байж үүнийг төлөвлөгөөнд тусгасан. Цаашид зөвхөн КОВИД-19 цар тахал бус өөр цар тахал, эсвэл байгалийн гамшигт нөхцөл байдал үүсэхэд хичээлээ хаадаг биш үргэлжлүүлдэг тогтолцоог бүрдүүлэхийн тулд тоног төхөөрөмж зайлшгүй шаардлагатай. Гэвч төсөв, санхүүтэй холбоотойгоор энэ ажлын биелэлт муу байна гэж харсан.

ОУБ-ын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын хэсгээс

Тоон судалгаанд хамрагдсан багш нараас 2021 оноос хойш БШУЯ, орон нутаг, сургуулиас ямар нэгэн ухаалаг төхөөрөмж (компьютер, таблет) өгсөн эсэхийг тодруулахад нийт багш нарын 44.9 хувь нь тийм, 55.1 хувь үгүй гэж хариулсан. Хэдий нэгдсэн байдлаар бүх багш нарыг ухаалаг төхөөрөмжөөр хангаагүй ч Говь-Алтай, Сэлэнгэ, Өмнөговь, Дархан-Уул зэрэг аймгийн орон нутгийн захиргаанаас багш нарыг зөөврийн компьютероор хангасан сайн жишээнүүд үнэлгээний явцад ажиглагдсан. Цахим төхөөрөмжийн дэмжлэг авсан багш нарын 70.1 хувь нь тус дэмжлэг сурагчдын хоцрогдлыг нөхөх ажилд нь үр нөлөө үзүүлсэн (24.4 хувь нь дундаж) гэж хариулснаас энэ төрлийн дэмжлэг ихээхэн шаардлагатай байсан нь харагдаж байна.

Дээрх мэдээллүүдээс харахад хосолсон сургалтын цахим сан бүрдүүлэх ажил улсын хэмжээнд хангалттай сайн хэрэгжсэн ба сургалтын дэд бүтэц сайжруулах чиглэлээр орон нутаг, сургууль бүр өөр өөрсдийн арга барилаар ажиллаж, тодорхой үр дүнд хүрсэн байна.

Стратеги 2.2. Суралцахуйг дэмжих тогтолцоог хэрэгжүүлэх

Цогц төлөвлөгөөнд туссан хамгийн гол үйл ажиллагаануудын нэг нь сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх зорилгоор суралцахуйг дэмжих тогтолцоог хэрэгжүүлэх явдал байв. Энэхүү тогтолцооны хүрээнд орчин үеийн сургалтын онолын нэг чиглэл болох өөрийн удирдлагатай суралцахуйн онолд тулгуурлаж, өөр хоорондоо уялдаа холбоо бүхий (i) Ерөнхий дэмжлэг, (ii) Нэмэлт дэмжлэг, (iii) Тусгай дэмжлэгийг хэрэгжүүлэхээр болсон.


ЕБС-ийн төлөөллүүдтэй хийсэн ярилцлагаас харвал сургууль бүр өөрсдийн хэмжээнд оношилгоонд үндэслэж сурагчдад ерөнхий, нэмэлт, тусгай дэмжлэг үзүүлж чадсан байна. Ерөнхий дэмжлэгийн хүрээнд оношилгооны үнэлгээгээр дунджаас дээгүүр сурагчдад “Сургалтын сайжруулсан хөтөлбөр”-өөр хичээл орох ёстой байсан. Ярилцлагад оролцсон зарим сургууль энэхүү хөтөлбөрийг ашигласан бол зарим нь сурагчдад тусад нь олон хувилбарт даалгавар боловсруулж хийлгэх зэргээр сургалтын үйл ажиллагааг зохион байгуулсан байна.

Харин нэмэлт дэмжлэгийн тухайд сургуулиуд сурагчдыг түвшнээр нь ангилж, зааварчилгаа бүхий сайжруулсан даалгавар өгч, цахим хичээлээс гадна танхимын сургалт, нэмэлт давтлага өгөх зэргээр ажиллажээ. Зарим сургуулийн багш нар гэртээ сурагчдыг авчирч хичээл заах тохиолдлууд байсан байна.

Оношилгооны дүн хэт доогуур, сэтгэл зүйн болон хөгжлийн тусгай хэрэгцээ бүхий сурагчдад тусгай дэмжлэг үзүүлэхээр төлөвлөгөөнд тусгасны дагуу зарим сургуулиудын тусгайлсан төлөвлөгөө гаргаж, гэрээр нь зочлох, тусгай танхим байгуулах сургалт орох зэрэг үйл ажиллагаанууд хэрэгжүүлжээ.

Тоон судалгаанд хамрагдсан багш нараас сүүлийн хоёр жилийн хугацаанд сургууль болон багш шаардлагатай сурагчдад ерөнхий, нэмэлт, тусгай дэмжлэг үзүүлсэн эсэхийг лавлахад нийт багш нарын 90 орчим хувь нь ерөнхий болон тусгай дэмжлэг үзүүлсэн гэсэн бол 56.7 хувь нь тусгай дэмжлэг үзүүлсэн байна. Харин тодорхой дэмжлэг үзүүлж чадаагүй багш нараас шалтгааныг тодруулахад дийлэнх нь дэмжлэг үзүүлэх заавар чиглүүлэг аваагүй, заавар чиглүүлэг авсан ч ажлын ачааллаас болж чадаагүй гэж хариулжээ.

График 6. Сургууль болон багш нар ерөнхий, нэмэлт, тусгай дэмжлэг үзүүлсэн эсэх (n=1,244)



Үнэлгээний хүрээнд цуглуулсан тоон болон чанарын мэдээллээс харахад суралцахуйг дэмжих тогтолцоо тодорхой хэмжээнд хэрэгжсэн байна. Гэвч уг үйл ажиллагааг бүрэн үр дүнтэй хэрэгжүүлэхэд ЕБС-пудад дараах хүндрэл бэрхшээл тулгарч байсныг ярилцлагын үеэр онцолсон билээ. Үүнд:

- Багш нарын ажлын ачаалал ихээр нэмэгдэж, асар их цаг хугацаа шаардаж байсан учир сурагч бүртэй ялгаатай арга барилаар тулж ажиллахад хүндрэлтэй байсан;
- Цахим төхөөрөмж, интернэтийн хүртээмжийн асуудлаас шалтгаалж сурагчид, ялангуяа нийгэм-эдийн засгийн статус доогуур өрхийн сурагчид цахим орчинд суралцахад хүндрэл учирсан;
- Сурагчдын анхаарал сул, дижитал ур чадвар дутмаг зэрэг шалтгаанаас болж цахимаар явуулсан хичээлүүд үр дүн багатай болох тохиолдол байсан;
- Анги танхимын хүрэлцээ муу, анги дүүргэлтийн тоо их байснаас шалтгаалсан хүндрэлүүд тулгарсан;
- Багш нар сурагчдыг гэртээ авчирч хичээллэснээс үүдэж Ковид-19 цар тахлын халдвар авах, тархах эрсдэл байсан;
- Үйл ажиллагааг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр, дэмжлэг байгаагүй зэрэг болно.

Энд дурдагдаж буй багш нарын ачаалал нэмэгдсэн асуудал цогц төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарсан голлох асуудлуудын нэг байсан ба тоон судалгаанд хамрагдсан нийт багш нарын 79.3 нь тус төлөвлөгөөг хэрэгжүүлснээр ажлын ачаалал нэмэгдсэн гэж хариулсан юм. Харин багшийн ачаалал нэмэгдсэн, цаг хугацаа их шаардсан зэрэг асуудлыг шийдвэрлэх зорилгоор суралцахуйг дэмжих тогтолцоонд дэмжигч багш, явуулын багш, дадлагын багш, дотуур байрны багш нарыг татан оролцуулахаар төлөвлөсөн боловч энэ ажлын хэрэгжилт ихээхэн хангалтгүй байсныг талууд дурдаж байв. Тухайлбал, тэтгэвэрт гарсан, ахмад багш нарыг суралцахуйг дэмжих

тогтолцоонд татан оруулсан ч санхүүгийн асуудал тулгамдсан байна. ЕБС-ийн төлөөллүүд зөвхөн багш нар хоорондоо хамтарч сурлагын хоцрогдлыг нөхөх чиглэлээр ажилласан бөгөөд багш нарын ачаалал нэмэгдэх, хүний нөөцийн дутагдалд орох явдал гарч байсныг мэдэгдсэн.

Оношилгооны дүнд тулгуурлан багш бүр төлөвлөгөө боловсруулж ажилласан. Мөн энэ үйл ажиллагаанд ахмад багшийг татан оролцуулж, тусгай өрөө гаргаж ажиллахаар болж 2 удаагийн уулзалт зохион байгуулсан боловч тухайн багш нарт урамшуулал олгох бололцоогүйгээс хэрэгжээгүй. Үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг байгаагүй нь тулгамдсан бэрхшээлийн нэг байв.

Өмнөговь аймгийн ЕБС-ийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагын хэсгээс


Стратеги 2.3. Явцын үнэлгээний өгөгдөлд суурилсан идэвхтэй суралцахуйг хэрэгжүүлэх

Сурагчдад өөрийн удирдлагатай сурах арга барил эзэмшүүлэх зорилгоор бие даан суралцах ажлын дэвтэр боловсруулж түгээхээр цогц төлөвлөгөөнд тусгажээ. Үүний хүрээнд БСҮХ-ээс 2021 онд “Сурагчийн бие даан суралцах ажлын дэвтэр”-ийг бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд боловсруулж, өөрийн вэбсайтад нээлттэй байдлаар байршуулсан байна¹⁴. Мөн БСҮХ-ээс холбогдох талуудад орсон сургалтуудаар тухайн дэвтрүүдийг ашиглах зааварчилгааг өгч ажиллажээ. Энэхүү томоохон хэмжээний ажлыг амжилттай зохион байгуулж, 2021-2022 оны хичээлийн жил эхлэхээс өмнө олон нийтэд түгээсэн нь ихээхэн сайшаалтай.

БСҮХ болон холбогдох байгууллагууд тухайн дэвтрүүдийг хэдэн сурагч ашиглаж, бодит үр дүнд хүрсэн талаар судалгаа, үнэлгээ хийгээгүй, хандалтын мэдээлэл гаргаагүй байна. Харин үнэлгээний асуулгад хамрагдсан багш нарын 58.4 хувь нь 2021-2022, 2022-2023 хичээлийн жилд уг дэвтрийг сургалтад ашигласан бөгөөд дэвтэр ашигласан багш нарын 61.2 хувь нь тус дэвтэр сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөхөд үр дүнтэй байсан гэж хариулжээ.

14 <http://202.5.202.91/mieredu/Home/Content/df1efc43-0c63-479e-be54-33de79ae634e>

График 9. “Сурагчийн бие даан суралцах ажлын дэвтэр”-ийн үр дүн (n=1,244)



Ганцаарчилсан ярилцлагад оролцсон ЕБС-иудын ихэнх төлөөллүүдийн мэдэгдсэнээр “Сурагчийн бие даан суралцах ажлын дэвтэр”-ийг бага ангийн сурагчид бүх судлагдахууны хүрээнд ашигласан байна. Дэлхийн Банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд тус дэвтрийг бага ангийн сурагчдад хэвлэж тараасан нь үр дүнтэй байжээ. Харин зарим сургуулийн хувьд ахлах ангид тус дэвтрийн хүрэлцээ муу байсан ба энэ нь дэвтрийг хэвлэж тараагаагүйтэй холбоотой байна.

Ахлах ангиудад дасгал ажлын дэвтэр хүрэлцээгүй. Харин бага ангийн хувьд байнга ажиллуулж байна. Бага ангийн хувьд математик, монгол хэл, дунд анги хими, физик, уран зохиолын хичээлүүдээр дасгал ажлын дэвэртэй ажилласан.

Баян-Өлгий аймгийн ЕБС-ийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагын хэсгээс

Товчхондоо, цогц төлөвлөгөөний хүрээнд боловсруулсан “Сурагчийн бие даан суралцах ажлын дэвтэр”-ийг сургуулиуд сургалтын хоцрогдол нөхөх зорилгоор ашиглаж, тодорхой үр дүнд хүрсэн байна.

Түүнчлэн, уг стратегид тусгагдсан өөр нэг арга хэмжээ нь “үндэсний хэмжээнд ашиглах явцын болон эцсийн үнэлгээний цахим платформ хөгжүүлж, нэвтрүүлэх” байв. Үнэлгээний мэдээлэл цуглуулалтын явцад энэхүү платформыг нэвтрүүлсэн талаарх мэдээлэл олдоогүй. Тиймээс “цахим платформ дахь үнэлгээний өгөгдөлд үндэслэн сурагчийн ахиц, хөгжлийг явцын үнэлгээгээр дэмжих” арга хэмжээ мөн адил хэрэгжсэн эсэх нь тодорхойгүй байна.

Стратеги 2.4. Өөрийн удирдлагатай суралцахуйг дэмжсэн, хосолсон сургалтын арга зүйг хөгжүүлэх

Энэхүү стратегийн хүрээнд (i) Хосолсон сургалтын арга зүйг хөгжүүлэх, (ii) Сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах стратеги, арга зүй танилцуулах, багш нарыг чадавхжуулах чиглэлээр багш нарт, (iii) Удирдах албан тушаалтнуудыг чадавхжуулах чиглэлээр ЕБС-ийн удирдах ажилтнуудад, (iv) Сурлагын хоцрогдлыг нөхөх арилгах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх чиглэлээр дэмжигч багш, явуулын багш, сэтгэл зүйч нарт сургалт орохоор төлөвлөгдсөн.

БЕГ-ын төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас үзэхэд 2021-2022 оны хичээлийн шинэ жилийн эхэнд зохион байгуулдаг төрөлжсөн сургалтыг хичээл сурлагын хоцрогдлыг арилгах, нөхөх цогц төлөвлөгөө болон сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй, менежментийн талаар нэгдсэн мэдээлэл ойлголт өгөх, тэдгээрийг хэрэгжүүлэх тодорхой арга, аргачлалд суралцахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор “Сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгахад дэмжлэг үзүүлэх” сэдвийн дор гурван үе шаттай сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулжээ. 4 өдөр, 32 цагийн уг сургалтыг Zoom болон Google meeting платформ ашиглан зохион байгуулж, 48,275 хүнийг хамруулжээ. Сургалтын эхний үе шатанд 109 хүнийг үндэсний сургагч багшаар бэлтгэсэн бол 2 дахь үе шатад БМДИ¹⁵ (bagsh.itpd.mn)-ийн сайтад байршуулсан материалуудыг багш, ажилтнууд бие даан судалж, дараа нь 8-р сард багтаан вебинар сургалт зохион байгуулсан. Харин 3 дахь үе шатад багшийн арга зүй, сурагчийн үнэлгээний жишиг и-контент бэлтгэн багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих төрөлжсөн, сонголтот, захиалгат сургалтаар хүргэсэн байна. Мөн “Хосолсон сургалтын арга зүй, менежментэд дэмжлэг үзүүлэх” арга зүйд үндэслэн судлагдахуун бүрээр “зөвлөмж” боловсруулан ЕБС-ийн багш нарт хүргүүлжээ.

Үнэлгээний багийн зүгээс ЕБС-ийн удирдах ажилтнууд, дэмжигч болон явуулын багш, сэтгэл зүйч нараас авах тоон судалгаа зохион байгуулаагүй тул (iii) болон (iv) сургалтын талаарх мэдээлэлгүй байна.

Харин тоон судалгаанд оролцсон нийт багш нарын талаас илүү хувь тус сургалтуудад хамрагдсан байна. Энэ нь тухайн арга хэмжээнүүдийн 2022 оны хүрэх зорилтод (сургалтад нийт багш нарын 80 хувь хамрагдана) хүрээгүй үзүүлэлт боловч арга хэмжээ тодорхой түвшинд хэрэгжсэн болохыг илтгэж байна.


15 Одоогийн БЕГ

График 7. Багш нарын сургалтад хамрагдсан байдал (n=1,244)



Харин уг сургалтуудад хамрагдсан багш нарын тал орчим хувь сургалтуудыг үр дүнтэй, тал орчим хувь нь дундаж гэж үнэлснээс харахад багш нарыг чадавхжуулах үйл ажиллагаа тодорхой үр дүнгээ үзүүлсэн байна.

График 11. Багш нарыг чадавхжуулах сургалтуудын үр дүн



Стратеги 2.5. Тэгш хамруулах сургалтыг дэмжих

Уг тайлангийн хоёр дахь бүлэгт өгүүлсэнчлэн цогц төлөвлөгөөнд тэгш хамруулах сургалтыг тусгаж, тодорхой арга хэмжээнүүд төлөвлөсөн нь сайшаалтай байна. Энэхүү стратегийн хүрээнд нийт 11 арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ч үнэлгээний баг голлох арга хэмжээнүүдийг үнэллээ.

Талуудын мэдээлснээр БШУЯ, БЕГ, Дэлхийн боловсролын түншлэл ОУБ хамтран "Тэгш хамруулах боловсролын сургагч багш бэлтгэх", "Тэгш хамруулан сургах боловсролын онол, арга зүй" сургалтыг зарим аймгуудад зохион байгуулж, 1,200 бага ангийн нарыг хамруулсан байна. Мөн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө бүхий 8 цагийн агуулгатай "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө"-ний зөвлөмжийг боловсруулсан ба хөгжлийн бэрхшээлийн төрөл хэлбэр, хүндрэлийн түвшин зэргээс хамааран 2034 хүүхэд ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж байгаа

аж.

Судалгаанд хамрагдсан нийт багш нарын 39.3 хувь нь 2021-2022 болон 2022-2023 оны хичээлийн жилд хөгжлийн бэрхшээлтэй сурагчидтай ажиллаж, хичээл заасан байна. Тэдгээр багш нарын 69.3 хувь нь хөгжлийн бэрхшээлээс үүдэх сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах ганцаарчилсан төлөвлөгөө хэрэгжүүлж ажиллажээ.

Мөн нийт багш нарын 32.9 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамран сургах болон алслагдсан, ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн хичээл, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах арга зүйн сургалтад хамрагдсан байна. Тухайн сургалтыг багш нарын 54.0 хувь нь үр дүнтэй, 39.9 хувь дундаж гэж үнэлжээ.

Ярилцлагад оролцсон ЕБС-иудын төлөөллүүдийн мэдээлж буйгаар тухайн сургуулиуд тусгай хэрэгцээтэй, ялгаатай бүлгийн хүүхдийн (хөгжлийн бэрхшээлтэй, амьжиргааны түвшин доогуур өрхийн, хүчирхийллийн хохирогч, дотуур байранд амьдардаг гэх мэт) сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах зорилгоор ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөнүүд боловсруулж, хэрэглэсэн байна. Зарим сургуулиуд тусдаа ажлын хэсэг байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажилласан бол зарим сургуулиуд амьжиргааны түвшин доогуур, эрсдэлд өртөж болзошгүй хүүхдүүдийн гэрээр эргэлт хийж, тодорхой дэмжлэгүүд үзүүлжээ. Гэвч зарим орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах бэлтгэгдсэн багш нар дутагдалтай байсан ба багш нар тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй ажилласны нэмэгдэл цалин авч чадаагүй талаар мөн дурдаж байсан.


Түүнчлэн энэ чиглэлээр Азийн хөгжлийн банк, Хүүхдийг ивээх сан, Дэлхийн боловсролын түншлэл, Жайка зэрэг ОУБ-ууд ажиллаж, Улаанбаатар хот болон орон нутгийн багш, ажилчдыг хамарсан сургалт зохион байгуулах, багш нарт арга зүйн дэмжлэг үзүүлэх, сургалтын модуль боловсруулах, шаардлагатай тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах зэрэг үйл ажиллагаануудыг хэрэгжүүлжээ.

Энэ мэт мэдээллээс харахад ЕБС-ууд ялгаатай бүлгийн, тусгай хэрэгцээтэй сурагчдад өөрсдийн бололцоогоор хүрч ажиллахыг хичээсэн байна.

Цогц төлөвлөгөөний “Хичээл, сурлагын хоцрогдлыг нөхөх” зорилтын үндсэн зорилго Ковид-19 цар тахлаас үүдэлтэй сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх байсан. Энэ хүрээнд үнэлгээний баг багш нараас Ковид-19 цар тахлаас үүдсэн сурагчдын сурлагын хоцрогдол 2022-2023 оны хичээлийн жилд нөхөгдөж чадсан эсэхийг тодруулахад нийт багш нарын 13.5 хувь санал нийлж, 49.2 хувь нь дундаж, 37.3 хувь нь санал нийлэхгүй гэж хариулжээ. Хэдий сурагчдын хоцрогдол нөхөгдсөн эсэхийг оношилгоо, судалгааны үр дүнд тулгуурлан нарийвчлан тодорхойлох

боловч сурагчидтай тогтмол ажиллаж буй багш нарын энэ талаарх бодол нэн чухал юм.

График 8. Сурагчдын сурлагын хоцрогдол нөхөгдсөн эсэх, багш нарын хувиар (n=1,244)



Цогц төлөвлөгөөний хоёр дахь зорилтын хүрээнд төлөвлөгдсөн ажлууд өмнөх зорилтын мөн адил боломжийн түвшинд хэрэгжсэн. Зорилтод тусгагдсан дэмжигч, дадлагын, явуулын багш ажиллуулах, багш нарыг зөөврийн компьютероор хангах зэрэг зарим ажлууд сул хэрэгжиж, ихэнх ажлууд төлөвлөсний дагуу бүрэн хэрэгжээгүй ч холбогдох байгууллага, сургууль бүр өөрсдийн хэмжээнд тодорхой үр дүн гаргажээ. Гэвч багш нарын өгсөн дээрх хариултаас харахад үндсэн зорилгоо биелүүлж чадсан эсэх нь эргэлзээтэй хэвээр байна.

Ярилцлагын үеэр энэхүү зорилтыг биелүүлэхэд ажиглагдсан эерэг болон сөрөг зүйлсийг тодруулахад оролцогчид дараах зүйлсийг дурджээ.

Эерэг хүчин зүйлс:

- Багш нар идэвхтэй хамтран ажиллаж, хамтын манлайлалд суралцсан.
- Сургуулиуд үүрэг, хариуцлагаа ухамсарлаж, идэвхтэй ажилласан.
- Багш, сурагчдын цахим орчинд ажиллах чадвар сайжирсан.
- Сурагчидтай эргэх холбоо сайжирсан.
- Сургалт явуулах цахим дэд бүтэц сайжирч, хичээл болон даалгаврын сантай болсон.
- Эцэг, эхчүүдийн дэмжлэг, оролцоо сайжирсан.

Сөрөг хүчин зүйлс:

- Сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх ажлуудад санхүүгийн хүндрэл их тохиолдсон. Сургуулийн удирдлага, багш нар өөрсдийн унаагаа ашиглаж байсан.

- Ангийн хүүхдүүд нь 5-6 түвшинд болж хуваагдаж, багш нар маш ачаалалтай ажилласан.
- Сайн түвшний сурагч бараг байхгүй, ихэнх нь хоцрогдолтой байсан. Хүүхдийн анхаарал төвлөрөлт сул, идэвх муу байсан.
- Зарим эцэг, эхийн хандлага, оролцоо тааруу, хүүхдүүдээ дэмжих байдал муу байсан.
- Анги дүүргэлт их, анги танхимын стандарт хангаж чадаагүй.

3.2.4. ЦОГЦ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС, СУРГАМЖ, АЖИГЛАЛТ

Үнэлгээний багийн зүгээс цугласан мэдээллүүд дээр үндэслэн цогц төлөвлөгөөний хэрэгжилтэд нөлөөлж буй дараах голлох хүчин зүйлс, сургамж, ерөнхий ажиглалтуудыг онцолж байна.

Цогц төлөвлөгөөг хэрэгжүүлэх ерөнхий зохион байгуулалт сул

Тус төлөвлөгөөний удирдлага, зохион байгуулалтыг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан, талуудын оролцоог ханган ажиллахаар тусгагдсан. Гэвч ярилцлагад оролцсон талуудын дурдаж буйгаар, мөн үнэлгээний багийн ажиглалтаар уг төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнтэй байдлыг хангах нэгдсэн удирдлага, зохион байгуулалт сул байна. Хэдий мэргэжлийн байгууллагууд өөрсдийн хариуцсан ажлуудаа тодорхой түвшинд хэрэгжүүлсэн боловч анх тавьсан үндсэн зорилгынхоо хүрээнд тэдгээр ажлуудыг хооронд нь хэрхэн уялдуулсан, ямар үр дүнд хүрч, үр нөлөө бий болгож буй талаар бүрэн мэдээлэлтэй байгууллага, нэгж, албан тушаалтан байхгүй байна. Цогц төлөвлөгөө хэрэгжих хугацаанд тус төлөвлөгөөг хэрэгжүүлэх байгууллага, оролцогч талууд үр дүн, үйл ажиллагааны ахицаа дүгнэх, мэдээлэл, туршлага солилцох, үйл ажиллагаа уялдуулах уулзалтууд зохион байгуулагдаагүй. Мөн цогц төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг нь уг төлөвлөгөөг боловсруулах болон хэрэгжүүлж эхлэх үе буюу 2021 онд нягт уялдаа холбоотой хамтран ажилласан бол яваандаа энэ байдал алдагдаж, нэгдмэл бус болж, байгууллагын ажил шинжтэй ажил болсон гэж үзэхээр байна. Үүнийг 2022 онд БМДИ нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын Ерөнхий Газар болж өргөжиж, БШУЯ-ны бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг БЕГ-т шилжсэнтэй холбоотойгоор ийм хийдэл гарсан байж болох юм.

Цогц төлөвлөгөөнд туссанаар Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын нэгж тус төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр

дүнгийн тайлагналтад дүгнэлт хийх үүрэгтэй байна. Ингэхдээ явцын хяналт-шинжилгээг тогтмол гүйцэтгэж, төлөвлөгөөний хэрэгжилтийг сайжруулах, 2021 болон 2022 онд жилийн гүйцэтгэлийн үнэлгээ хийж, төлөвлөгөөний хэрэгжилт, тулгарсан бэрхшээл, ололт зэргийг тодорхойлох ёстой байв. Гэтэл энэ хяналт-шинжилгээ, үнэлгээнүүд огт хийгдээгүй болох нь ажиглагдсан. Тухайлбал, уг хөндлөнгийн үнэлгээний мэдээлэл цуглуулалтын ажил эхэлж байх үе буюу 2023 оны 10 сард БШУЯ руу албан бичиг хүргүүлж, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүд, хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээнд тусгагдсан 2021 болон 2022 оны зорилтот түвшний биелэлтийн мэдээллийг хүссэн боловч нэгдсэн мэдээлэл байхгүй гэдэг хариу авсан. Ганцаарчилсан ярилцлагын үеэр мэргэжлийн байгууллагуудын төлөөллүүдээс энэ талаар тодруулахад нэгдсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний ажил бүрэн хийгдээгүй нь батлагдсан. Харин тухайлсан нэг арга хэмжээ болон төсөл дээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тохиолдлууд байсан. Өөрөөр хэлбэл, 2021 болон 2022 онд төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлээгүй, нэгдсэн хяналт-шинжилгээ хийгээгүй байна. Түүнчлэн, ганцаарчилсан ярилцлагаас үзэхэд ихэнх мэргэжлийн байгууллагуудын жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуурт цогц төлөвлөгөөний шалгууруудтай уялдсан шалгуур тусгагдаагүй байна.

Дээрх асуудлуудаас болж цогц төлөвлөгөөний хүрээнд мэргэжлийн байгууллагуудын хэрэгжүүлсэн ажлууд орон нутаг, сургуулийн түвшинд хэр үр нөлөө үзүүлсэн, зорилтот үр шим хүртэгчдэдээ хүрч чадсан эсэхэд талууд бүрэн хариулж чадахгүй байв. Тиймээс төлөвлөгөөнд туссан арга хэмжээнүүд тухайн орон нутаг, сургуулийн чадавх, нөөц, удирдлагын манлайлал, хичээл зүтгэл, ялгаатай арга барилаас шалтгаалж ялгаатай түвшинд хэрэгжиж, ялгаатай үр дүнд хүрчээ. Хэдий тийм боловч ихэнх оролцогч талууд, ялангуяа ЕБС-иуд Ковид-19 цар тахлаас үүдэлтэй сурлагын хоцрогдлын асуудлыг ихээхэн анхаарч, өөрсдийн үүрэг, хариуцлагаа дор бүрнээ ухамсарлан, боломжит арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж, идэвхтэй ажилласан нь харагдсан.

Талуудын хамтын ажиллагаа сайжирсан

Хэдийгээр цогц төлөвлөгөөний ерөнхий удирдлага, зохион байгуулалт сул байсан ч тухайлсан арга хэмжээнүүдийн хүрээнд талуудын хамтын ажиллагаа сайн байсан гэж ярилцлагад оролцсон ихэнх төлөөллүүд санал нийлж байв. Тухайлбал, Ковид-19 цар тахлын хөл хорионы үед теле хичээл зохион байгуулах ажилд мэргэжлийн байгууллагууд маш түргэн шуурхай зохион байгуулалтад орж, хамтран ажиллаж, багш нарыг татан оролцуулж, богино хугацаанд ихээхэн үр дүнд хүрсэн байна. Энэ мэт хамтын ажиллагаанаас харахад боловсролын салбарын мэргэжлийн

байгууллагууд, мөн ИНБ, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд мэдэгдэхүйц хэмжээнд сайжирсныг талууд дурдаж байв.

Нэг үеэ бодвол мэргэжлийн байгууллагууд болон салбар хоорондын хамтын ажиллагаанд ахиц дэвшил гарсан. Жишээлбэл, багшийн хөгжлийг дэмжсэн цахим платформ нэвтрүүлэхэд БЕГ тендер зарлаж, тендерт ТББ орж байна. Тухайн ТББ тухайн платформ дээр сургалт байршуулахын тулд их дээд сургуулиуд, боловсролын салбарын мэргэжлийн байгууллагууд, орон нутгийн БШУГ-ууд, мэргэжлийн багш нар зэрэг бүх төлөөллүүдтэй хамтран ажиллаж байх жишээтэй.

ОУБ-ын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын хэсгээс

Цогц төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцсон өөр нэг нэг тал бол олон улсын байгууллагууд байна. Дэлхийн Банк, Азийн Хөгжлийн Банк, Швейцарын Хөгжлийн Агентлаг, НҮБ-ын Хүүхдийн сан, Японы хүүхдийг ивээх сан, Дэлхийн боловсролын түншлэл зэрэг олон улсын байгууллагууд тодорхой төсөл, хөтөлбөрийн хүрээнд цогц төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан нь чанарын судалгааны үр дүнгээс харагдаж байсан. Эдгээр байгууллагуудын анхаарлыг Ковид-19 цар тахлаас шалтгаалсан сурагчдын хичээл, сурлагын хоцрогдлын асуудалд хандуулах, үүнд зориулсан үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхэд БШУЯ идэвхтэй ажиллаж, татан оролцуулсан талаар талууд дурдаж байв. Олон улсын байгууллагууд зөвхөн БШУЯ-тай хамтран ажилласан бус мэргэжлийн байгууллагууд, ИНБ, орон нутаг, ЕБС-иудтай мөн идэвхтэй хамтран ажиллаж байжээ.

Үнэлгээний үед ажиглагдсан өөр нэг сайшаалтай зүйл нь орон нутаг дахь үр дүнтэй хамтын ажиллагаа байв. Орон нутгийн төлөөллүүдтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагаас харахад 2021, 2022 онд зөвхөн БШУГ болон ЕБС-иуд бус орон нутгийн удирдлагууд, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Цагдаагийн алба, Нийгмийн бодлогын хэлтэс зэрэг байгууллагууд энэ асуудлаар идэвхтэй хамтран ажиллаж, санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна. Үүн дээр нэмээд эцэг эх, асран хамгаалагчид хүүхдүүдийнхээ боловсролын асуудалд анхаарч, сургууль, багш нарт дэмжлэг үзүүлсэн тохиолдолд сурлагын хоцрогдлыг нөхөхөд эергээр нөлөөлж байсныг дурдсан.

Аймаг, орон нутгаас төсөв хөрөнгөөр дэмжлэг үзүүлж, тоног төхөөрөмж, интернэтийн асуудлыг шийдэж, зөвлөх багш нарын баг ажиллуулах, багш бүрийг зөөврийн компьютероор хангах, БШУГ-ын ажил хариуцсан мэргэжилтэн сургууль дээр байнга зөвлөн туслах, хянах зэрэг ажлууд хийснээр сургалтын орчин сайжирсан.

Өмнөговь аймгийн БШУГ-ын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын хэсгээс

Харин зарим талуудын онцолж буйгаар БШУЯ нь цогц төлөвлөгөөний хэрэгжилтэд хувийн хэвшлийн оролцоог хангах, татан оролцуулах, хамтран ажиллах, тэднээс санхүүгийн дэмжлэг авах, хөрөнгө босгох тал дээр сул ажиллаж, томоохон санаачилгууд хэрэгжүүлж чадаагүй байна.

Цогц төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд санхүүгийн бэрхшээл ихээхэн тулгарсан

Ганцаарчилсан ярилцлагад хамрагдсан оролцогчид, ялангуяа орон нутгийн БШУГ, ЕБС-ийн төлөөллүүд цогц төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд тулгарсан хамгийн хүнд бэрхшээл санхүүгийн бэрхшээл байсан талаар дурдсан. Ковид-19 цар тахлын үед сурагчидтай эргэн холбогдох, явуулын үйлчилгээ үзүүлэх, гэрээр нь зочлох, цахимаар сургалт орох, дэмжигч багш ажиллуулах зэрэг ажлуудад хөрөнгө мөнгө ихээхэн шаардаж байсан ч төлөвлөгөөг хэрэгжүүлэх нэмэлт санхүүжилт байгаагүй байна. Тайлангийн өмнөх хэсэгт дурдсанчлан Ковид-19 цар тахлын үед сурагчид олон түвшинд хуваагдаж, багш нар түвшний бүрийн сурагчидтай ялгаатай арга барилаар, нэг бүрчлэн ажиллах шаардлага гарсан. Цахимаар хичээл заахтай холбоотойгоор нэмэлт даалгавар, хичээлүүд бэлтгэж, ихээхэн ачаалалтай, нэмэлт цагаар ажиллаж байсан ч тэдний илүү цагийн хөлсийг олгоогүй зэрэг тохиолдол гарчээ.

Үүнээс болж сургууль төсвөө хэмнэх, багш нар өөрсдөөсөө мөнгө гаргах байдлаар зарим арга хэмжээнүүдийг зохион байгуулсан байна. Тухайлбал, цахим хичээлд шаардлагатай интернэтийн зардал, сурагчдын гэрээр зочлоход шаардлагатай унаа болон шатахууны зардал зэргийг багш нар өөрсдийн хөрөнгөөр зохицуулж байжээ.

Сургууль өөрсдөө зохицуулаад дотуур байрны хүүхдүүдийн хоолны мөнгө, үдийн цайны зардлыг хэмнээд, зарцуулж байсан. Гэхдээ тэр хангалттай биш байсан. Унаа, шатахууны асуудал хэцүү байв. Унаа хөлсөлж авах боломжгүй байсан тул багш нар өөрсдийн унааг ашиглаж, шатахуунаа хийгээд явсан. Хөдөө айлд очиход гар цайлгах чихэр, печень зэргийг аваад очдог байсан.

Баян-Өлгий аймгийн БШУГ-ын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын хэсгээс

Түүнчлэн, цогц төлөвлөгөөнд “үйл ажиллагааны санхүүжилтэд аймаг нийслэл, сум, дүүргийн орон нутаг хөгжүүлэх сангийн төсвийн 10%-ийг зарцуулна” гэж заасан боловч ярилцлагад оролцсон БШУГ-ын төлөөллүүд энэ талаар мэдээлэлгүй байна.

Цогц төлөвлөгөөний дэд бүтэц, технологитой холбоотой арга хэмжээнүүд, үүн дотор багш нарыг зөөврийн компьютероор, сурагчдыг таблетаар хангах зэрэг ажлуудыг хэрэгжүүлэхэд мөн санхүүгийн бэрхшээл тулгарсан байна.

Зарим талуудын үзэж буйгаар эдгээр ажлуудад шаардлагатай хөрөнгө босгоход БШУЯ идэвхтэй ажиллаж чадаагүй, хувийн хэвшилтэй хамтран ажиллаж, дэмжлэг авах боломжтой байсан аж.

Хэдий санхүүгийн асуудлууд тулгарч байсан ч өмнө дурдсанчлан ОУБ-ууд, орон нутгийн засаг захиргаа, эцэг эх, асран хамгаалагчид тодорхой хэмжээнд санхүүгийн туслалцаа үзүүлж, тодорхой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ үзүүлсэн нь сайшаалтай байна.

КОВИД-19 цар тахал болон бусад цаг үеийн нөхцөл байдал

Энэхүү цогц төлөвлөгөө нь сүүлийн жилүүдэд дэлхий дахины өмнө тулгарсан хамгийн том хямрал болох Ковид-19 цар тахлын үед хэрэгжсэнээрээ онцлогтой. Тиймээс ч жирийн үед хэрэгждэг бусад төлөвлөгөөнүүдтэй харьцуулахад илүү хүндрэл бэрхшээлүүдтэй тулгарч байжээ. Цогц төлөвлөгөө хэрэгжиж байх үед улс даяар онц байдал зарлаж, бүтэн болон хэсэгчилсэн байдлаар хөл хорио тавигдаж, нийгэм-эдийн засгийн байдал хүндэрсэн байсан ч төлөвлөгөөнд тусгагдсан ихэнх үйл ажиллагаанууд тодорхой хэмжээнд хэрэгжсэн байгаа нь сайшаалтай.

Ковид-19 цар тахлаас үүдэлтэй сурагчдын хичээл, сурлагын хоцрогдлыг асуудлыг бүх нийтээр анхаарч, цогц төлөвлөгөөг шинэ хичээлийн жил эхлэхээс 3 сарын өмнө баталсан. Үүнээс шалтгаалж богино хугацаанд тус төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг гүйцэтгэж, түргэн шуурхай ажиллаж чаджээ. Мөн дээр дурдсанчлан тухайн үед БМДИ нь БЕГ болон өргөжиж, үйл ажиллагааны чиглэл нь өөрчлөгдөж, дотоод институтчлэлийн үйл явц өрнөж байсны зэрэгцээ цогц төлөвлөгөөг хэрэгжүүлэх, бэлтгэх ажлууд давхцаж байсан ч хариуцсан үүргээ биелүүлэхэд анхаарч ажилласан байна.

3.3. ЦОГЦ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Цогц төлөвлөгөөний гурав дахь зорилтод хичээл, сурлагын хоцрогдлыг арилгах/тогтворжуулах арга хэмжээнүүдийг төлөвлөж, багш нар нотолгоонд суурилсан сайн туршлагаа хуваалцаж, хамтран хөгжих, сургууль, орон нутаг залруулга бүхий дэмжих тогтолцоог бие даан хэрэгжүүлдэг болохоор зорьсон. Энэ зорилтод тусгагдсан арга хэмжээнүүд 2023-2024 оны хичээлийн жилд хэрэгжих тул бүрэн хэрэгжиж дуусаагүй гэж үзэн одоогоор гарсан үр дүн, хэрэгжилтийг энэ бүлэгт үнэлсэн. Түүнчлэн, цогц төлөвлөгөөний хүрээнд хэрэгжсэн ажлууд цаашид тогтвортой хэрэгжих боломжтой эсэх, цаашид сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх хэрэгцээ шаардлага байгаа эсэх талаар тодрууллаа.

Ярилцлагад оролцсон орон нутгийн БШУГ болон ЕБС-ийн төлөөллүүд орон нутаг, сургуулиуд сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах дэмжих тогтолцоог бие даан хэрэгжүүлэх чадавхтай болсон гэдэг дээр бүгд санал нийлж байна. Цогц төлөвлөгөөний арга хэмжээнүүдээс ЕБС-ийн багш нар дараах сайн туршлагуудыг хуримтлуулжээ.

- Багш нар эцэг эхтэй хамтран ажиллах, сурагчдын гэрээр зочилж, тулж ажиллах туршлагатай болсон.
- Багш нарын цахим сургалт зохион байгуулах ур чадвар нэмэгдэж, интерактив хичээлүүдэд сурагчдыг идэвхтэй оролцуулах сайн туршлага хуримтлуулсан.
- Сурагчдад зориулсан даалгаврын сантай бүрдүүлж, арвижуулсан.
- Тусгай дэмжлэг шаардлагатай сурагчидтай ажиллах, эцэг эх, асран хамгаалагчидтай нь хамтрах ажиллах туршлага нэмэгдсэн.
- Сурагчдыг түвшнээр нь ангилж, ялгаатай байдлаар хичээл заах, даалгавар бэлтгэх чадвартай болсон.
- Хосолсон сургалтын дэд бүтэц (интернэтийн хурд, төхөөрөмжийн тоо гэх мэт) сайжирсан.

Түүнчлэн цогц төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг цаашдаа хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөцийн эх үүсвэрүүд бүрдсэн эсэхийг тодруулахад хүний болон техникийн нөөц хангалттай хэмжээнд бүрдсэн, сайжирсан гэж үзжээ. Харин төсөв, санхүүгийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай гэж үзэж байна.

Сургуулийн хэмжээнд бий болсон сайн туршлагуудаас гадна улсын хэмжээнд цаашдын сургалтын үйл ажиллагаанд ашиглаж болохуйц хосолсон сургалтын дэд бүтэц, цахим хичээлийн платформ, даалгаврын сан, бие даан суралцах ажлын дэвтэр, “Ногоон гэрэл” үйл ажиллагааны удирдамж зэрэг хэрэглэгдэхүүнүүд бий болсон нь сайшаалтай.

Багш нарын заах арга барил, дэмжих тогтолцоог хэрэгжүүлж буй сайн туршлагыг өөр хоорондоо хуваалцах, танилцуулах нь цогц төлөвлөгөөний тогтвортой байдлыг сайжруулах чухал ажлын нэг. Энэ хүрээнд ШХА-аас үндэсний хэмжээний гурван удаа чуулга уулзалтуудыг зохион байгуулж, багш нарын сайн туршлагын түгээх дэлгэрүүлэхэд идэвхтэй ажиллажээ. Тухайлбал, 2021 онд 5 салбар хуралдаан бүхий, 10,900 орчим хүн оролцсон цахим чуулга уулзалтыг зохион байгуулж, Монгол Улсад болон дэлхийн дахинд бий болсон сайн туршлага, хичээлүүдийг багш нарт хүргэх, түгээсэн байна. Мөн Булган аймгийн Хялганат тосгонд 5 аймгийн 30 сургуулийн төлөөлөл оролцсон чуулган зохион байгуулж, хээрийн кэмп загвараар сургуулиудын гүйцэтгэсэн ажлуудыг бодитоор харуулж, сайн туршлагуудыг түгээжээ. Харин 2023 онд 450 орчим хүн оролцсон үндэсний чуулган зохион

байгуулж, сургуулиуд гарааны үнэлгээгээ хэрхэн сайжруулсан талаар бусдадаа тайлагнах, танилцуулах боломж олгожээ.

Түүнчлэн ШХА-аас www.esd.mn цахим платформыг нэвтрүүлж, үүгээр дамжуулан 10 орчим сургуулийн сургуульд суурилсан сургалтын хөтөлбөрийг бусад сургуулиудад түгээж, бусад улс орнуудын сургалтын хөтөлбөрийн давуу талуудыг сургууль, багш нарт хүргэжээ. Энэхүү платформд 6 сар орчмын хугацаанд 40 мянга гаруй хандсан сайн үр дүн гаргажээ.

Үнэлгээний баг мөн тоон судалгаанд хамрагдсан нийт багш нараас цогц төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлсэн сурагчдын хоцрогдлыг нөхөх, арилгах ажлаа бусад багш нар, холбогдох талуудад танилцуулж, туршлагаа хуваалцсан эсэхийг тодруулахад 47.3 хувь тийм, 52.7 хувь нь үгүй гэж хариулсан байна. Харин “тийм” гэж хариулсан багш нарын 53.1 хувь нь туршлагаа хуваалцсан ажлыг нь өөр сургуулийн удирдлага, бусад багш нар ажилдаа нэвтрүүлсэн тохиолдлыг мэднэ гэсэн юм.

Мөн сургалтын хөтөлбөрийн агуулгын хоцрогдлыг арилгах зорилгоор судлагдахуунуудыг ангилж, хариуцсан судлагдахуун бүрийн онцлогт тохируулан мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх багш нарын мэргэжлийн бүлгүүд бий болсон нь хоцрогдол нөхөх, арилгах ажлуудыг сайжруулах, тогтмолжуулахад дэмжлэг болсон.

Энэхүү цогц төлөвлөгөө нь гурван жилийн хугацаанд хэрэгжихээр батлагдсан ч сурагчдын сурлагын хоцрогдол нөхөхөд үр дүнгээ үзүүлсэн болон цаашдын сургалтын үйл ажиллагаанд үр ашгаа өгөхүйц сайн туршлагуудыг хадгалан, тогтмолжуулах шаардлагатай. Ярилцлагад оролцогчдын үзэж буйгаар цаашид ч сурагчдын хоцрогдол гарсан хэвээр байх тул энэ чиглэлийн ажлуудыг үргэлжлүүлэх хэрэгтэй аж.

Сурагчдын хичээл, сурлагын хоцрогдол ямар түвшинд байгааг тухай бүрд нь тодорхойлж, тохирсон үйл ажиллагааг тогтмол явуулна. Одоо ингээд сурлагын хоцрогдол ариллаа гэж харахгүй байгаа. Тухай бүрд нь хоцрогдлыг арилгаад шийдээд явах шаардлагатай.

БСҮХ-ийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагын хэсгээс

Бид багш нараас цаашид сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгахын тулд ямар арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай талаар тодруулахад дараах нийтлэг хариултуудыг өгсөн. Үүнд (хариултын давтамжаар эрэмбэлсэн):

- Эцэг эх, асран хамгаалагчийн хамтын ажиллагааг сайжруулах;
- Сурагчтай ажиллах боломжийг нэмэгдүүлж, цаг олгох, ажлын ачааллыг багасгах;

- Сурагчдад нэмэлт давтлага өгөх;
- Нэг ангид суралцах сурагчдыг тоог стандартад нийцүүлэх, багасгах;
- Сургуулийн түвшинд хоцрогдол арилгах цогц төлөвлөгөө гаргах;
- Сурагчдын хандлагыг сайжруулж, ухамсрыг дээшлүүлж, идэвхжүүлэх;
- Хөтөлбөрийн агуулгад өөрчлөлт оруулж, боловсронгуй болгох, хөнгөвчлөх;
- Сурагч бүрийг оношлон, түвшнийг нь үнэн зөв тогтоох;
- Сурагч бүрд тохирсон арга зүй боловсруулж, тулж ажиллах;
- Сурагчид бие даан ажиллах дэвтэр боловсруулах, хэрэгжүүлэх;
- Сурагчдын түвшинд тохирсон ялгаатай даалгавар бэлтгэх зэрэг болно.

Энд сурагчдыг оношлох, давтлага, нэмэлт даалгавар өгөх, бие даан ажиллах дэвтэр боловсруулах зэрэг нийтлэг арга хэмжээнүүдээс гадна “Эцэг эх, асран хамгаалагчийн хамтын ажиллагааг сайжруулах”, “Сурагчтай ажиллах боломжийг нэмэгдүүлж, цаг олгох, ажлын ачааллыг багасгах”, “Нэг ангид суралцах сурагчдыг тоог стандартад нийцүүлэх, багасгах” зэрэг багшаас төдийлөн хамаарахгүй ажлууд дурдагдсан нь анхаарал татаж байна. Олон багш нарын үзэж буйгаар сурагчдын хоцрогдлыг нөхөх, арилгахад эцэг эх, асран хамгаалагчийн оролцоо хамгаас чухал байна. Тиймээс цаашид энэ чиглэлийн ажлууд төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай харагдаж байна.

Мөн өмнөх бүлгүүдэд дурдсан мэдлэг чадварын хувьд ялгаатай түвшний хүүхдүүдтэй ажиллах, ялгаатай түвшний даалгаврууд бэлтгэх, цахим сургалтад бэлтгэх зэргээр цогц төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд багш нарын ачаалал нэмэгдсэнтэй дийлэнх багш нар санал нийлж байсан. Гэтэл тэдэнд сурагчидтай тулж ажиллах, хоцрогдол нөхөхөд цаг зарцуулах боломж тааруу, бусад бичиг цаасны ажлууд их байгаа нь томоохон асуудал болж байна. Үүнээс гадна нэг багш хэт олон сурагчидтай ажиллах, анги дүүргэлтийн тоо их байгаа нь бүтээмжтэй, үр дүнтэй ажиллахад мөн сөргөөр нөлөөлдөг байна. Тиймээс дээр дурдсан арга хэмжээ, асуудлуудад сайтар анхаарах нь цаашид хичээл, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгахад нэн чухал байна.

Эцэст нь, аливаа төсөл, хөтөлбөр, төлөвлөгөөний тогтвортой байдлыг хангахад тогтмол хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нь чухал ач холбогдолтой байдаг. Хяналт-шинжилгээ, үнэлгээнээс гарсан үр дүнгүүд талуудын эргэх холбоог сайжруулж, туршлага, сургамжаасаа суралцах боломжийг олгодгоороо онцлогтой. Гэвч цогц төлөвлөгөөний хэрэгжилтэд тухай бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажил маш хангалтгүй байсан нь тогтвортой байдлыг бууруулах сөрөг нөлөөтэй байна. Цаашид төлөвлөгөөнд туссан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг бүх шатанд үнэлж, хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээнд тусгагдсан зорилтот түвшний биелэлтийг нарийн мэдээлэлд үндэслэн тодорхойлох зайлшгүй шаардлагатай юм.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Дэлхий дахин Ковид-19 цар тахалтай нүүр тулж, улс орны нийгэм-эдийн засгийн байдал хүндэрсэн цаг үед боловсролын салбарт тулгарсан сурагчдын сурлагын хоцрогдлын асуудалд онцгойлон анхаарч, БШУЯ-аас “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хичээл, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах цогц төлөвлөгөө /2021-2023/” боловсруулж, баталсан нь нэн чухал алхам болжээ. Тус асуудлыг шийдвэрлэх олон улсын туршлагад тулгуурласан цогц арга хэмжээнүүдийг төр болон иргэний нийгмийн төлөөллүүд хамтран төлөвлөж, тодорхой шийдэл санал болгосноороо боловсролын салбарт хамааралтай бүхий л оролцогч талуудын анхаарлыг татаж, асуудлыг ил болгосон чухал ач холбогдолтой юм.

Цогц төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд талуудын хамтын ажиллагаа, төлөвлөгдсөн арга хэмжээнүүдийн уялдаа холбоог хангах, нэгдмэл зорилгын хүрээнд чиглүүлэх ерөнхий удирдлага, зохион байгуулалт сул байсан нь үнэлгээний үр дүнгээс харагдлаа. Цогц төлөвлөгөөний хэрэгжилтийг улсын хэмжээнд хариуцсан тусгай алба, нэгж байгаагүйгээс хэрэгжилтийг хянах, үр дүн, үр нөлөөг үнэлэх хяналт-шинжилгээ, үнэлгээнүүд мөн хийгдээгүй байна. Үүнээс шалтгаалж талууд цогц төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар бүрэн цогц мэдээлэлгүй, хийсэн ажлууд нь түвшин түвшиндээ хэрхэн үр нөлөө үзүүлж буйг хянах, үйл ажиллагаануудаа сайжруулах боломжийг хязгаарлажээ.

Гэвч мэргэжлийн байгууллагууд тус төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг зохих хэмжээнд хэрэгжүүлж, тодорхой үр дүнд хүрчээ. Цар тахлын хүнд үед ЕБС болон багш нар өөрсдийн үүрэг хариуцлагыг бүрэн ухамсарлаж, сурагчдын нийгэм-сэтгэлзүйн байдлыг дэмжих, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах чиглэлд чадавх, туршлага, нөөц, манлайлал, онцлогоосоо хамаарч ялгаатай арга барилаар ажиллаж, ялгаатай үр дүнгүүд гаргажээ.

Тухайлбал, цахим хичээлийн сан бүхий платформыг нэвтрүүлж, сурагчийн бие даан суралцах ажлын дэвтрийг боловсруулж, “Ногоон гэрэл” үйл ажиллагааны удирдамж гаргаж, хосолсон сургалтын дэд бүтцийг сайжруулан, сургуулийн сэтгэл зүйчдийг ажиллуулж эхэлсэн зэрэг сайн туршлагаудыг нэрлэж болно. ЕБС-ууд мөн мэргэжлийн байгууллагуудаас

гаргасан хэрэглэгдэхүүнүүдийг үйл ажиллагаандаа тодорхой хэмжээнд ашиглаж, сурлагын хоцрогдолтой болон ялгаатай бүлгийн сурагчдад өөрсдийн бололцоогоор хүрч ажиллаж, түвшинд нь тохирсон ялгаатай сургалтууд зохион байгуулж, байнгын харилцаа холбоотой байхад анхаарсан байна. Эдгээрийн үр дүнд багш нарын хосолсон сургалт зохион байгуулах, хоцрогдолтой сурагчидтай ажиллах ур чадварууд сайжирсан зэрэг сайн туршлага бий болжээ.

Цогц төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд ЕБС-иудад тулгарсан түгээмэл асуудал нь санхүүгийн бэрхшээл байв. Цахимаар сургалт зохион байгуулах, сурагчидтай эргэн холбогдох, нэмэлт сургалт орох, гэрээр нь зочлох зэрэг үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг шаардлагатай байсан ч нэмэлт төсөв хөрөнгө байгаагүйн улмаас багш нар өөрсдийн зардлаар санхүүжүүлэх шаардлага гарсан байна. Тиймээс талууд БШУЯ, орон нутгийн захиргааны байгууллагаас цогц төлөвлөгөөг сургуулийн түвшинд хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө босгох, төсөв хуваарилахад хангалтгүй ажилласан гэж үзэж байна.

Эцэст нь, үнэлгээний мэдээлэл цуглуулалтад хамрагдсан ЕБС-ийн багш нар болон бусад мэргэжлийн байгууллагуудын төлөөллүүдийн үзэж буйгаар сурагчдын сурлагын хоцрогдол бүрэн арилаагүй бөгөөд цаашид ч энэ асуудал гарсан хэвээр байх тул хоцрогдол арилгах чиглэлээр тогтмол үйл ажиллагаа хэрэгжүүлж, түүнийхээ хэрэгжилтийг хянаж, энэхүү тайланд дурдагдсан тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байна.

ТАВ. БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨМЖ

- Үндэсний хэмжээнд хэрэгжих цогц төлөвлөгөө боловсруулж, баталж буй тохиолдолд түвшин бүрд мэргэжлийн байгууллагууд, орон нутаг дахь холбогдох талуудын хамтын ажиллагааны уялдаа холбоог харгалзан, хэрэгжүүлэх бүтэц, механизм байгуулан ажиллуулдаг байх;
- Цогц төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг зааж өгөөгүй, мэдээлэл хангалтгүй байснаас үүдэн эцэг эх асран хамгаалагчид болон багш нар хувиасаа зардал гаргасан байна. Тиймээс Хоцрогдол арилгах цогц төлөвлөгөөтэй ижил түвшний бодлогын баримт бичиг хэрэгжүүлэх бол сургуулиуд дээр хэрэгжих “нэмэлт үйл ажиллагаа”-г санхүүжүүлэх эх үүсвэрийг шийдэж, шилжүүлж байх;
- БШУЯ ба мэргэжлийн байгууллагуудын хяналт шинжилгээний төлөвлөгөөнд үндэсний хэмжээнд хэрэгжиж байгаа цогц төлөвлөгөөний шалгуурууд үзүүлэлтийг оруулж бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт мониторинг, үнэлгээ хийж тайлагнадаг байх;
- Үнэлгээнд оролцогчдын дийлэнх нь Хоцрогдол арилгах төлөвлөгөөг тодорхой хэмжээнд мэдэж байсан нь сайшаалтай. Тиймээс БШУЯ-наас боловсруулан баталсан аливаа бодлого, шийдвэрийг хэрэгжилтийн түвшинд таниулах, сурталчлах үйл ажиллагааг тогтмол хийж байх;
- Гамшиг, онцгой байдлын үед болон дараа нь алслагдмал бүс нутагт амьдардаг малчдын хүүхдүүдэд хэрхэн хүрч боловсрол эзэмшүүлэх чиглэлээр нэгдсэн чиглэл, бодлого, төлөвлөгөө, төсөвтэй байх;
- Гамшиг, онцгой байдлын үеийн боловсролын үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоо дэмжлэг чухал тул, олон нийт эцэг эх рүү хандсан мэдээлэл харилцааны стратеги, сувагтай байх;
- Гамшгийн үеийн бэлэн байдлын төлөвлөгөөнд Ковид-19-өөс авсан сургамж, “Хоцрогдол арилгах төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад бий болсон сайн туршлагуудыг багш, сургуулиудад түгээх, сайжруулан боловсруулах ажлын төсвийг жил бүр орон нутагт төсөвлөж, сургуулиуд руу хуваарилдаг байх;

- Гамшиг, онц байдлын үед сургуулийн үйл ажиллагааг тодорхой хугацаагаар зогсоосон тохиолдолд үдийн хоолны үйлчилгээг нийгэм-эдийн засгийн статус доогуур өрхийн хүүхдүүдэд огт тасалдуулахгүй байхад анхаарах;
- Гамшигийн үеийн төлөвлөгөөнд багш, суралцагчдын сэтгэцийн эрүүл мэндийн асуудлыг тусгасан байх;
- Ямар ч шалтгаанаар сурлагын хоцрогдолд орсон суралцагчид байх учир сургуулийн түвшинд сурлагын хоцрогдлыг арилгах төлөвлөгөөтэй байхад анхаарч, сургууль, багш нарт арга зүйн дэмжлэг үзүүлэх;
- Сургуулийн түвшинд сурлагын хоцрогдлыг үнэлэх аргачлалуудыг бэлэн болгох, нэвтрүүлэх
- Урт хугацаандаа анги дүүргэлтийг бууруулах, анги танхимын стандартыг барих чиглэлээр бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Сурлагаар хоцрогдсон хүүхдүүдтэй ажиллах багшийн ачааллыг бууруулахын тулд сайн дурын дэмжигч сургагч болон дадлагажигч багш нарыг бодлогоор татан оролцуулах;
- “Бие даан суралцах ажлын дэвтэр”-ийн ашиглалт үр дүнгийн талаар судалгаа хийж, сайжруулах;
- Сурлагын хоцрогдолтой хүүхдэд болон ялгаатай хэрэгцээтэй суралцагчдад чиглэсэн ганцаарчилсан төлөвлөгөө боловсруулж ажиллахыг дэмжих;
- Суурь ур чадваруудын хоцрогдлыг цаг тухайд нь нөхөх байнгын төлөвлөгөөтэй байх;
- 3 түвшний дэмжлэгийг (Ерөнхий, нэмэлт, тусгай) сургалтын үйл явцад нэвтрүүлж байнга ашиглах аргачлал, арга зүйг боловсруулж түгээн дэлгэрүүлэх;
- Багшийг ажиллах төхөөрөмжөөр бүрэн хангах, сургуулийн дэд бүтцийг бодлого төлөвлөгөөтэй сайжруулах;
- Нийгэм эдийн засаг статус доогуур, дэд бүтэцгүй алслагдсан газар амьдардаг суралцагчдыг шаардлагатай төхөөрөмжөөр хангах;

ХАВСРАЛТ

Доорх хүснэгтэд үнэлгээний тоон судалгаанд хамрагдсан ЕБС-ийн багш нарын байршлыг дэлгэрэнгүй байдлаар харууллаа.

Хүснэгт Х-5. Тоон судалгаанд хамрагдсан багш нарын тоо, байршлаар

Аймаг	Давтамж	Хувь
Архангай	13	1.0%
Баян-Өлгий	135	10.9%
Баянхонгор	68	5.5%
Булган	20	1.6%
Говь-Алтай	7	0.6%
Говьсүмбэр	32	2.6%
Дархан-Уул	51	4.1%
Дорнод	4	0.3%
Завхан	42	3.4%
Орхон	21	1.7%
Өвөрхангай	37	3.0%
Өмнөговь	206	16.6%
Сүхбаатар	92	7.4%
Сэлэнгэ	4	0.3%
Төв	2	0.2%
Увс	20	1.6%
Ховд	25	2.0%
Хөвсгөл	90	7.2%
Хэнтий	3	0.2%
Улаанбаатар	372	29.9%
Нийт	1,244	100.0%

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

